



ТӨСӨЛ ХЭРЭГЖҮҮЛЭГЧ:
“ЭРДЭС ГРУПП” ХХК

**СЭЛЭНГЭ АЙМГИЙН ХҮДЭР СУМЫН
“ТӨМӨРТЭЙН ТӨМРИЙН ХҮДРИЙН ОРД”
ТӨСӨЛ**

/БО-ны менежментийн төлөвлөгөө/

2023 он

ОРШИЛ

“Эрдэс Групп” ХХК нь улс орон болон бүс нутгийн эдийн засгийн өсөлтөнд хувь нэмэр оруулахын зэрэгцээ нээлттэй байдал, тогтвортой хөгжлийг үнэт зүйлээрээ тодорхойлсон. Тиймээс байгаль орчны хамгааллын асуудалд тэргүүлэх ач холбогдол өгдөг.

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны 10-р сарын 29-ний өдрийн А/618 тоот тушаал болон бусад Монгол улсын хууль, журам, тогтоолын шаардлагад нийцүүлсэн бөгөөд компанийн 2023 оны төлөвлөгөөнд байгаль орчны тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэхэд нэн тэргүүнд хэрэгжүүлэх шаардлагатай ажлуудыг төлөвлөн тусгасан.

Төмөртэйн голын төмрийн хүдрийн ордод ҮХЯ, АМГТХЭГ-ын Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн 2020 оны 12 дугаар сарын 10-ний өдрийн хуралдаанаар батлагдсан ТЭЗҮ-ийн тодотголд техникийн нөхөн сэргээлтийн ажлыг 8 дахь жил буюу 2028 оноос хийхээр тусгасан. Учир нь ордын хүдрийн биет нь босоо байрлалтай ба ил аргаар 100м хүртэл гүнд олборлолтын ажил явагдах тул техникийн нөхөн сэргээлтийн ажлыг зэрэг явуулах боломжгүй. Иймд 2028 оноос тус ордыг ашиглаж дуустал техникийн болон биологийн нөхөн сэргээлтийн ажлыг бүрэн хийж дуусгахаар төлөвлөн ажиллаж байна.

2023 онд “Эрдэс Групп” ХХК-ний “Төмөртэйн гол” Уулын баяжуулах үйлдвэр нь захиргаа аж ахуйн хэсэг, уулын хэсэг, баяжуулах үйлдвэрийн хэсэг, хүдэр тээвэрлэх хэсэг, үйлдвэр техникийн хэсэг гэсэн бүтэц зохион байгуулалттай ажиллах бөгөөд уул, техникийн хэсэг 342.5 мян.м³ хөрс хуулж, 508.5 мян.тн буюу 121.1 мян. м³ төмрийн хүдрийг ордын баруун биетийн С-6, В-7, В- 8, С-9 блокоос олборлож, үйлдвэрийн хэсэг 465,1 мян.тн төмрийн хүдрийг хуурай соронзон сеперацийн аргаар боловсруулж, 52.46%-ийн дундаж агуулгатай 328.64 мян.тн төмрийн бүхэллэг баяжмал үйлдвэрлэн гаргана.

I. ГЕОЛОГИЙН ХЭСЭГ

I.1 Районы физик газарзүй, эдийн засгийн товч тодорхойлолт:

Тус орд нь Сэлэнгэ аймгийн Хүдэр сумын нутагт Улаанбаатар хотоос хойт зүгт 360 км, Дархан хотоос зүүн хойш 140 км, Хүдэр сумаас баруун урагшаа 32 км зайд оршдог.

Номенклатур: М-48-83

Газарзүйн солбицол: Өргөрөг $49^{\circ} 40' 15''$ - $49^{\circ} 40' 54''$

Уртраг $107^{\circ} 12' 30''$ - $107^{\circ} 15' 00''$

Засаг захиргаа: Сэлэнгэ аймгийн Хүдэр сум

Газарзүйн тогтоц: Хэнтийн уулархаг мужийн баруун хойд хэсэгт Ерөө ба Хүдэр голын дундах салбар уулсад хамаарна. Гадаргуугийн хувьд 1000-1250 м үнэмлэхүй өндөртэй нам уул дов толгодорхог рельефтэй, уул толгодын хажуу бэлийн налуу их ба голын хөндийгөөр эрчимтэй сархиагжсан байдаг.

Ус цаг уур: Эх газрын эрс тэс уур амьсгалтай, цаг агаарын өөрчлөлт огцом, температурын хэлбэлзэл их, агаарын дулааны хамгийн өндөр хэм нь 38°C , хамгийн хүйтэн хэм нь -48°C , жилийн дундаж дулааны хэмжээ -1.9°C , жилийн дундаж борооны хэмжээ 240 мм, цас уналтын хэмжээ 240-530 мм, газар хөлдөлтийн гүн 2.0-2.5 м.

Дэд бүтэц: Ордын талбай нь зам харилцаа харьцангуй сайн хөгжсөн Дархан – Сэлэнгийн бүс нутагт хамрагддаг бөгөөд Улаанбаатар – Дархан – Сэлэнгийн – Хүдэр асфальтан замтай сайжруулж зассан шороон замаар холбогддог.

Үйлдвэр нь төвийн эрчим хүчний шугамд холбогдсон 35КВ-ийн 35/6-1600квт-ын өндөр хүчдэлийн дэд станцтай.

I.2 Ордын геологийн тогтоц:

Төмөртэйн голын ордын талбай нь тунамал гаралтай венд-кембрийн насны доломитжсон шохойн чулуу, элсэн чулуу, занарын үелэл, гүний үүсэлтэй боржингийн төрлийн чулуулгууд болон хувирлын дунд үүссэн роговик, скарн зэрэг чулуулаг, төмрийнхүдрийн биетүүдээс бүрдэл болдог. Мөн дөрөвдөгчийн сэвсгэр хурдас хучаас байдлаар оролцоно.

Венд-кембрийн насны тунамал чулуулгууд нь тектоник хөдөлгөөнд өртөж геоантиклиналь өргөгдлийн дагуу эгц босоо байрлалтай атираа үүсгэж оршдог. Гүний үүсэлтэй боржин, боржиндиорит, цахиртдиорит зэрэг чулуулгууд нь Венд-кембрийн тунамал чулуулгуудыг зүсч нэвчиж байрласан бөгөөд тэдгээрийн хил заагийн хэсгээр хүчтэй хувирал явагдаж үр дүнд нь роговик, скарн зэрэг хувирмал чулуулгууд үүссэн байна.

I.3 Хүдрийн биетийн тодорхойлолт:

Ордын хүдрийн биетүүд нь Төмөртэйн төмрийн хүдрийн ордын баруун урд жигүүрийн үргэлжлэл хэсэг юм. Энэ хэсэг дээр манай компани өөрийн хөрөнгөөр хайгуулын ажил гүйцэтгэж хүдрийн 2 биетийг нарийвчлан тогтоон нөөцийг тооцож “Төмөртэйн голын төмрийн хүдрийн орд” гэж нэрлэн нарийвчилсан хайгуулын тайланд тусгасан. Эдгээр биет нь Төмөртэйн голын дэнж, уулын бэл хажууг дагаж байрлах бөгөөд 20-25 м зузаан сэвсгэр хурдсаар хучигдсан.

Эдгээр биет нь баруун урдаас зүүн хойшоо 55⁰-58⁰-ын чиглэлд сунаж тогтсон, зүүн биетийн урт 490 м, зузаан нь 12-50 м, дунджаар 23,9 м, баруун биетийн урт 310 м, зузаан нь 18-37 м, дунджаар 23,5 м. Биетүүд нь 250 м хүртэл гүнд үргэлжлэх бөгөөд бараг эгц босоо байрлалтай, зүүн урагш 80⁰-85⁰-аар налж байрлана. Хүдрийн биетүүдийн ерөнхий хэлбэр сунасан мишэл /линз/ байрлалтай боловч хажуу хана руу хармай, цүлхэн үүсгэсэн, төгсгөл хэсэг нь салбарлаж салаалан агуулагч чулуулаг руу түрж орсон байна. Хоёр биет нь өөр хоорондоо 700 орчим метр зайтай ба зэрэгцээ байрлалтай. Хүдрийн биетийн дунд ялангуяа тэдгээрийн зах хэсгээр агуулагч роговик, скарны үе линз маягийн үлдэгдэлүүд нэлээд тааралдана.

I.4 Хүдрийн бүтэц, найрлага:

Төмөртэйн голын ордын төмрийн хүдрийн гол эрдэс нь магнетит ба мартит 5 %-иас хэтрэхгүй. Төмрийн усан исэл пирит, пирротин бага хэмжээгээр оролцоно. Хүдрийн бус эрдсээс пироксин, амфибол, хлорит, кальцит, эпидот, гялтгануур зэрэг эрдэс зонхилно.

Үйлдвэрийн ач холбогдол бүхий хүдэр бүрдүүлэгч гол эрдэс болох магнетит нийт хүдрийн 63-76%-ийг эзлэх бөгөөд 0,04-5,0мм хүртэл хэмжээний мөхлөгүүдтэй. Ихэвчлэн цул текстур бүхий хүдэр үүсгэсэн байна. Гэвч магнетитын хүдэрт агуулагч чулуулгаас үлдсэн пироксен, амфибол, эпидот, хлорит зэрэг эрдэсүүд, скарнын үлдэгдэл хэсгүүд нэлээд түгээмэл тааралдах бөгөөд эдгээр нь үелэг, толболог, линзлэг бүтцүүдийг үүсгэсэн.

Хүдрийн биетийн хэмжээнд түүнийг бүрэлдүүлэгч эрдсүүдийн тархалт жигд биш. Ордын хүдрийг сульфидын агуулга болон эрдсийн найрлагаас нь хамаарч бага хүхэртэй исэлдсэн, анхдагч бага хүхэртэй, анхдагч хүхэрлэг гэсэн 3 бүлэгт хуваадаг.

I.5 Ордын гидрогеологи:

Орд байрлаж буй районд тархсан газар доорхи усыг агуулж байгаа хурдас чулуулгийг тэдгээрийн үүсэж хуримтлагдсан геологийн цаг үе, литологийн найрлага, газар доорхи усны хөдөлгөөн, хуримтлагдах нөхцлөөр нь дараах байдлаар ялгаж авч үзжээ.

Ангилалдаагүй дээд ба орчин үеийн дөрөвдөгчийн уст цогцолбор /QIII-QIV/: Энэ уст цогцолбор нь районы баруун хэсэгт буюу Сөдөт уулын баруун хэсэгт Хандгайт голын бэлчир орчмоор, зүүн хэсгээр Сөдөт уулын зүүн талд Шулуун гол, Сөдөт голын бэлчир орчмоор 55км² орчим газрыг хамран тогтжээ. Энэ цогцолборын ус агуулагч чулуулаг нь элсэнцэр, элс хайрга, дайрга, бул чулуу зэргээс тогтоно.

Газар доорхи усны илрэх гүн 1.0-38.0 м-ийн хооронд хэлбэлзэх агаад, ус агуулагч чулуулгийн хамгийн их зузаан 55.4 м-т хүрнэ. Энэ уст цогцолборын аллювиаль, пролювиаль гаралтай хурдсанд өрөмдсөн цооногийн ундарга Хандгайтын хэсэгт 15.15 м түвшний бууралтанд 12.0 л/сек, 2 түвшний бууралтад 7.0л/сек-ийн хооронд хэлбэлзжээ.

Харин уулархаг хэсгийн делювиаль хурдсанд хамгийн их ундарга нь 20.3 м түвшний бууралтанд 0.8 л/сек-ээс хэтэрдэггүй. Уст давхарга нь даралтгүй чөлөөт гадаргатай. Усны химийн найрлага гол төлөв гидрокарбонат сульфат, магнийн кальцийн найрлагатай. Усны эрдэсжилт 0.25-0.48 гр/л, ерөнхий хатуулаг 4.15-6.36 мг-экв/л-т хэлбэлзэнэ.

Энэ уст цогцолборт агуулагдаж байгаа газар доорхи ус нь ундарга сайтай мөн усны химийн найрлага, эрдэсжилт болон бусад үзүүлэлтүүд нь хүн амын ундааны шаардлагыг бүрэн хангаж байгаа тул төвлөрсөн усан сан хангамжид өргөн ашиглах боломжтой.

Доод пермийн насны гүний чулуулгийн уст цогцолбор /P1/: Доод пермийн гүний чулуулагт агуулагдаж байгаа уст цогцолбор нь районы баруун хэсгээр Хандгайт голын хойт хэсэгт тохиолдоно. Ус агуулагч чулуулагт боржин, боржиндиорит орох ба тэдгээрийн өгөршлийн бүс, ан цавшилд нилээд орсон хэсгээрээ газар доорхи ус хуримтлагдан байрлах ба уулын хормойн боржинлог чулуулагт 0.9м-ээс ус илэрдэг.

Энд цооногийн ундарга 16.1м түвшний бууралтанд 1.1л/сек байна. Энэ уст цогцолборын газар доорхи ус нь гидрокарбонат-кальцийн найрлагатай. Эрдэсжилт нь 0.48гр/л болно.

Доод пермийн настай гүний чулуулагт агуулагдаж байгаа газар доорхи ус нь химийн найрлагаар хүн амын ундаанд тохирч байгаа ч гэсэн усны ундарга бага учраас төвлөрсөн усан хангамжинд ашиглах боломжгүй.

Рифей-доод кембрийн чулуулаг нь эрозийн бүсээс дээш орших ба энэ насны чулуулаг тархсан газруудаар газар доорхи усны илэрц бараг тохиолддоггүй.

1.6 Ордыг ашиглах уул-техникийн нөхцөл:

Орд газар 920-1050м үнэмлэхүй өндөртэй бөгөөд уулс хоорондын болон налуугийн 20-24м хүртэл сэвсгэр хурдсаар хучигдсан байдаг ч хөндийн өргөн нь 400-500м. Төмөртэйн голын төмрийн хүдрийн ордыг гадаргуугаас 100м хүртэл гүнд ил аргаар ашиглах боломжтой юм. Хүдрийн биетэд нэвтэрсэн цооногуудын босоо зүсэлтээр эхний 12-30м гүнд исэлдлийн бүс тархсан байдаг ба энэ хэсэгт хүдрийн хатуулаг V-VII зэрэглэлд хамаарагддаг бөгөөд исэлдлийн бүсээс доош хүдэр нь аажмаар анхдагч цул хүдэрт шилжин VII-XI хатуулагтай болдог. Энэ нь агуулагч чулуулгаасаа арай бага ан цавтай гэсэн үг юм.

Хүдрийн эзэлхүүн жин түүнд агуулагдах төмрийн агуулгаас хамаарч янз бүр байх бөгөөд 4,2-4.6тн/м³ байна. Агуулагч чулуулгийг бүрдүүлэгч үндсэн чулуулаг нь роговик, бага хэмжээгээр элсэн чулуу, занар, гантигжсан шохойн чулуу байх бөгөөд 20-60м хүртэл гүнд өгөршилд орж ан цавшилт үүссэн. Хүдрийн биетийг хучиж тогтсон дунджаар 22м зузаан сэвсгэр хурдас болон дельювиаль, пролювиаль гаралтай хурдас чулуулгийн хатуулаг III-IV зэрэгт хүрнэ. 22-45м гүнд агуулагч чулуулаг ан цавлаг тогтворжилт муу байдаг ба үүнээс доош чулуулаг бүрэн тогтворжилттой болж IX-XI хатуулгын зэрэгт хүрнэ. Хүдрийн биетүүдийн босоо ба хэвтээ хажуу, агуулагч чулуулаг дотор 2-6м хүртэл зузаантай бутралын бүс элбэг тохиолдоно.

Агуулагч чулуулгийн эзэлхүүн жин роговикт 2.7-3.2, занарлаг чулуулагт 2.8-3.1, элсэн чулуу болон занарт 2.7-3.05 байх ба дунджаар 2.8-2.9тн/м³ болж байна.

II. УУЛЫН ХЭСЭГ

II.1 Уурхайн ашиглалтын хил хязгаар:

2023 онд нийт 342.5 мян.м³ хөрс хуулж, 508.5 мян.тн хүдэр ил аргаар олборлоно. Тус онд ордын баруун биетэд хөрс хуулалт, хүдэр олборлолтын ажил явуулахаар төлөвлөж байна.

II.2 Ашиглалтын нөөц:

Уурхайн ашиглалтын нөөцийг ТЭЗҮ-д тусгасанаар ашиглалтын үеийн хаягдалбохирдолтын хэмжээгээр тооцож авсан.

Ашиглалтын үед хүдрийн хаягдлыг 3,24%-иар, бохирдолтыг 5,02%-иар авч, ашиглалтын нөөцийг тооцсон. Тооцоог Маягт № 2.1-д үзүүлэв.

II.3 Уурхайн жилийн хүчин чадал:

Ил уурхайн хүчин чадлыг тооцохдоо карьерт ажиллах экскаваторын бүтээлийг гаргаж, уг бүтээлтэй уялдуулан бусад машин механизмын бүтээлийг сонгон авдаг аргачлалыг баримтлав.

II.3.1 Экскаваторын бүтээл:



Орд газрын хөрсний чулуулгийн хатуулаг $f=8-11$, хүдрийн хатуулаг дунджаар $f=11$ байгаа тул өрөмдлөг тэсэлгээний аргыг хэрэглэнэ. Мөргөцгийн ажлын бус доголын өндөр 4.0м, доголын налуугийн өнцөг $65-75^{\circ}$ байна. Уулын ажилд CAT-390F 1ш, CAT-375L 1ш экскаваторуудыг ажиллуулна.

II.3.2 Экскаваторын хоногийн бүтээл:

а. CAT 390F

$$Q_{\text{хон}} = \frac{3600 * E * T * K_{\text{ш}} * K_{\text{ца}} * K_{\text{уч}}}{t * K_{\text{с}}}$$

Энд: 3600 -цагийг секундээр илэрхийлсэн;

E-шанаганы багтаамж – 5.4 м³;

T -хоногт ажиллах хугацаа - 24 цаг;

K_ш -шанага дүүргэлтийн коэффициент – 0,86;

K_а-цаг ашиглалтын коэффициент – 0,83;

K_у-ур чадварын коэффициент – 0,8;

t-циклийн үргэлжлэх хугацаа - 35 сек;

K_с -сийрэгжилтийн коэффициент -1,5;

$$Q_{\text{хон}} = \frac{3600 * 5.4 * 24 * 0.86 * 0.83 * 0.8}{35 * 1.5} = 5074.76 \text{ м}^3 / \text{хон}$$

CAT 390F экскаваторын жилийн хүчин чадал:

$$Q_{\text{жил 390F}} = Q_{\text{хон}} * T_{\text{ж}}$$

Энд: $Q_{\text{хон}}$ - хоногийн хүчин чадал

$T_{\text{ж}}$ - жилд ажиллах хоног

$$Q_{\text{хон}} = 5074.76 \text{ м}^3 \times 64 \text{ хоног} = 324.8 \text{ мян. м}^3$$

б. CAT 375L

$$Q_{\text{хон}} = \frac{3600 * E * T * K_{\text{ш}} * K_{\text{ца}} * K_{\text{уч}}}{t * K_{\text{с}}}$$

Энд: 3600 - цагийг секундээр илэрхийлсэн;

E-шанаганы багтаамж -5 м³;

T_х -хоногт ажиллах хугацаа - 24 цаг;

K_ш -шанага дүүргэлтийн коэффициент – 0,86;

K_a -цаг ашиглалтын коэффициент – 0,83;

K_u -ур чадварын коэффициент – 0,8;

t - циклийн үргэлжлэх хугацаа - 40 сек;

K_c - сийрэгжилтийн коэффициент -1,5;

$$Q_{\text{хон}} = \frac{3600 * 5 * 24 * 0.86 * 0.83 * 0.8}{40 * 1.5} = 4111.48 \text{ м}^3 / \text{хон}$$

SAT375L экскаваторын жилийн хүчин чадал:

$$Q_{\text{жил 375L}} = Q_{\text{хон}} * T_{\text{ж}}$$

Энд: $Q_{\text{хон}}$ - хоногийн хүчин чадал

$T_{\text{ж}}$ - жилд ажиллах хоног

$$Q_{\text{хон}} = 4111.48 \text{ м}^3 \times 64 \text{ хоног} = 263.1 \text{ мян. м}^3$$

$$\Sigma Q = Q_{\text{жил 390F}} + Q_{\text{жил 375L}} = 324.8 \text{ мян. м}^3 + 263.1 \text{ мян. м}^3 = 587.9 \text{ мян. м}^3$$

Энэ тооцооноос үзэхэд экскаваторуудын жилийн хүчин чадал нь төлөвлөгөөт **576.6 мян.м³** уулын цул ачихад хангалттай хүрэлцэж байна.

II.3.2 Автосамосвалын бүтээл:

Уурхайн автозамын налуугийн хэмжээ 6⁰-8⁰, хөрс тээвэрлэлтийн зай талдаа 700-1000 м, төмрийн хүдэр тээвэрлэлтийн зай талдаа 2500 м байна. Тээвэрлэлтэнд 60 тонны даацтай MT86 маркын 8ш, 60 тонны даацтай HOWO371 маркын 4ш автосамосвалууд ажиллана.

Автосамосвалын цагийн бүтээл:



$$Q_{\text{ац}} = \frac{3600}{T_p} * \frac{q_a * K_c}{\gamma} * K_d$$

Энд:

q_a - автосамосвалын даац - 60тн;

K_d -даац ашиглалтын коэффициент – 0,98;

T_p -нэг рейсийн хугацаа - 15мин;

γ -уулын цулын эзэлхүүн жин - 4.2 т/м³;

K_c -уулын цулын сийрэгжилт - 1,5;

$$Q_{\text{ац}} = \frac{3600}{900} * \frac{60 * 1,5}{4,2} * 0,98 = 83.88 \text{ м}^3/\text{цаг}$$

Автосамосвалын ээлжийн бүтээл:

$$Q_{\text{эж}} = Q_{\text{ац}} * T * K_{\text{ца}} = 83.88 * 12 * 0.83 = 835.4 \text{ м}^3/\text{ээлж}$$

$K_{\text{ца}}$ -цаг ашиглалтын коэффициент / $K_{\text{ца}}=0,83/$

Автосамосвалын хоногийн бүтээл:

$$Q_{\text{хон}} = Q_{\text{эж}} * k = 835.4 * 2 = 1670.8 \text{ м}^3/\text{хоног}$$

n-хоногт ажиллах ээлжийн тоо /n=2/

Уурхайд ажиллах автосамосвалуудын нийт жилийн бүтээл:

$$\sum Q = Q_{\text{хон}} * T_{\text{ж}} * N$$

Энд: $Q_{\text{хон}}$ - хоногийн хүчин чадал

$T_{\text{ж}}$ - жилд ажиллах хоног / $T_{\text{ж}}=64$ хоног/

N – автосамосвалын тоо /N=8 ш/

$$\sum Q = 1670.8 * 64 * 8 = 855.4 \text{ мян. м}^3/\text{жил}$$

Энэ тооцооноос үзэхэд автосамосвалуудын жилийн хүчин чадал нь төлөвлөгөөт **576.6 мян.м³** уулын цул тээвэрлэхэд хангалттай хүрэлцэж байна.

II.3.3 Бульдозерийн бүтээл



Уулын цулыг түрэх тэгшлэх ажилд бульдозер D9R – 1ш ажиллуулна.

Бульдозерийн цагийн бүтээл:

L-Тэгшлэх талбайн урт /L=300м/

$B_{\text{бз}}$ - Тэгшлэх зурвасын өргөн / $B_{\text{бз}} = 4.3\text{м}/$

L_{sy} -Хусуурын урт / $L_{\text{sy}} = 4.3\text{м}/$

a -Зурвасын давхцах өргөн /a=0.35м/

n-нэг зурваст тэгшлэлт хийх тоо /n=2/

U-тэгшлэлт хийх үеийн хурд /U=0.94м/с/

$t_{\text{эр-мөр}}$ хооронд эргэлт хийх хугацаа / $t_{\text{эр}}=10\text{с}/$

$$Q_{\text{цо}} = \frac{3600 * (B_{\text{бз}} - a) * L}{k * (\frac{L}{U} + t_{\text{эр}})} = \frac{3600 * (4.3 - 0.35) * 300}{2 * (\frac{300}{0.94} + 10)} = 5906 \text{ м}^3 / \text{цаг}$$

Бульдозерийн ээлжийн бүтээл:

$$Q_{\text{эб}} = Q_{\text{цб}} * T * K_{\text{ца}} = 5906 * 12 * 0.83 = 58823 \text{ м}^2 / \text{ээлж}$$

T -ээлжийн үргэлжлэх хугацаа / $T=12$ цаг/

$K_{\text{ца}}$ -ээлжийн цаг ашиглалтын коэффициент / $K_{\text{ца}}=0.83/$

Бульдозерийн хоногийн бүтээл:

$$Q_{\text{хб}} = Q_{\text{эб}} * k = 58823 * 2 = 117647 \text{ м}^2 / \text{хон}$$

хоногт гарах ээлжийн тоо / $n=2$ /

Бульдозерийн жилийн бүтээл:

$$Q_{\text{жб}} = Q_{\text{хб}} * N = 117647 * 64 = 75.3 \text{ мян. м}^2 / \text{жил}$$

N -Жилд ажиллах хоног / $N= 64$ хоног/

Дээрх тооцоонуудаас үзэхэд уулын ажилд хэрэглэх техникүүдийн хүчин чадал нь энэ оны төлөвлөгөөг биелүүлэхэд хангалттай хүрэлцэх нь харагдаж байна.

II.4 Уулын ажил явагдах ашиглалтын хугацаа:

Хөрс хуулалтын ажил 7-р сарын 1-нээс, хүдэр олборлолтын ажил 8-р сарын 1-нээс тус тус эхэлж, 9-р сарын 2-ны хооронд төлөвлөж байна.

Уулын хэсгийн ажиллах хоног:

VII/1 – IX/2-ны хооронд нийт төлөвлөн ажиллах хоног – 64 жил/хоног

Уулын ажил явагдах ашиглалтын хугацааг хүснэгт №1-т үзүүлэв.

Хүснэгт №1

№	Үндсэн үзүүлэлтүүд	Хэмжих нэгж	Дүн
1	Нийт ажиллах хоногийн тоо	Хоног	64
2	Сард ажиллах хоногийн тоо	Хоног	31
3	Хоногт ажиллах ээлжийн тоо	Ээлж	2
4	1 ээлжийн үргэлжлэх хугацаа	Цаг	12

II.5 Уурхайн олборлолт ба капитал ажил:

Өмнөх онуудын уулын ажлын нөлөөгөөр эвдрэлд өртсөн талбай болон 2023 онд уулын ажилд талбайг нэмж өртөхгүй, ашиглалт эхэлсэн үеэс өссөн дүнгээр нийт 45.7 га талбай болно.

Хөрс хуулалтын ажлыг явуулахдаа ашиглалтын түвшингүүдийг тэлэх замаар, хүдэр олборлолтыг суналын дагуу уулын ажлыг явуулна.

Баяжуулах үйлдвэрийг төмрийн хүдрээр тасралтгүй хангахын тулд хөрс хуулалтынажлыг төлөвлөлтийн дагуу явуулж, 1 сар үйлдвэрлэхэд хүрэлцэхүйц байхаар хүдэр бэлдэж, овоолго үүсгэн нөөцлөнө. Уурхайн автозамыг “Ил уурхайн аюулгүй ажиллагааны дүрэм”-ийн дагуу гүйцэтгэнэ.

II.6 Ашиглалтын систем, түүний үндсэн хэмжигдэхүүнүүд:

Уулын чулуулгийг өрөмдөж тэслэн, сийрэгжүүлсэн уулын цулыг экскаватороор ачиж, автосамосвалаар хөрсийг гадаад овоолгод, хүдрийг баяжуулах үйлдвэрийн хүдрийн овоолгод тээвэрлэнэ.

Уурхайн үндсэн хэмжигдэхүүнүүд нь:

Ажлын бус доголын өндөр – 4 м

Ажлын доголын өндөр – 20 м

Хамгаалалтын тавцангийн өргөн - 2 м

Доголын налуугийн хэмжээ – $65-75^{\circ}$

Ажлын талбайн хамгийн бага өргөн – 10 – 20 м

Замын налуу - $6^{\circ}-8^{\circ}$

II.7 Өрөмдлөг тэсэлгээний ажил:

Тус орд газрын үндсэн чулуулаг нь роговик, занарлаг болон элсэн чулуулаг зэрэг болно.

Чулуулгийн хатуулгийн коэффициент проф.Протодьяконовын ангиллаар $f=8-11$, СНиП-ийн өрөмдлөгийн зэрэглэлээр VIII ангилалд хамаарагдаж байна.

Өрөмдлөгийн ажлыг SANDVIK компанийн Titon-500 маркийн өрмийн машинаар өрөмдөнө.



Тэсэлгээний ажлыг мэргэжлийн байгууллага болох “Майн Тех Бласт” ХХК-тай гэрээ байгуулж гүйцэтгүүлнэ.

II.7.1 Өрмийн тоног төхөөрөмж, тэсэлгээний цооногуудын бэлдэлт:

Урьд онуудын бутлагдлын чанарыг үндэслэн 140мм–ийн диаметртэй цооног өрөмдөж, тэсэлгээний ажил гүйцэтгүүлж байхаар гүйцэтгэгч компанитай гэрээ байгуулжажиллана.

Өрмийн машины бүтээл болон хэрэгцээг тооцоолон Хүснэгт №3–д, Өрмийн машины техникийн тодорхойлолтыг Хүснэгт №2–д тус тус үзүүлэв.

Хүснэгт №2

№	Үзүүлэлтүүд	Нэгж	Тоо хэмжээ
1	Өрмийн машины марк		Titon-500
2	Цооногийн диаметр	мм	140
3	Өрөмдөх цооногийн гүн	м	10
4	Өрөмдөх талбайн налуу	град	90
5	Штангины диаметр	мм	114
6	Штангины урт	мм	5000
7	Хөдөлгүүрийн төрөл	САТ	С-11
8	Шахалтат хийн даралт	бар	24
9	Хөдөлгүүрийн багтаамж	м ³ /цаг	22
	Хурд	км/цаг	2.8-4.0
10	Станокийн:Жин	кг	19500
11	Урт	мм	11434
12	Өргөн	мм	2480
13	Өндөр	мм	3125

Хүснэгт №3

д/д	Үзүүлэлтүүд	нэгж	Тоо, хэмжээ
1	Чулуулагийн зэрэг, өрөмдлөгөөр		VIII-XI
2	Ээлжийн үргэлжлэх хугацаа	мин	720
3	Ээлжийн бэлтгэл, төгсгөлийн хугацаа	мин	30
4	Операторын хувийн хэрэгцээний хугацаа	мин	30
5	Өрөмдлөгийн үндсэн ба туслах хугацаа	мин	660
6	Ээлжийн бүтээл	м	182,5
7	Хоногийн бүтээл	м	365,0
8	Жилд ажиллах хоног	хоног	64
9	Жилийн бүтээл	м	23360
10	Өрмийн машины тоо	ш	1

II.7.2 Тэсэлгээний ажил:

Боловсруулж батлуулсан өрөмдлөг тэсэлгээний ажлын паспортыг үндэслэн ил уурхайн аюулгүй ажиллагааны журмыг мөрдөж ажиллана.

Тус онд “Майнтех Бластинг” ХХК нь гэрээний дагуу тэсэлгээний ажлыг гүйцэтгэх ба тэсрэх бодис хэрэгслийг зориулалтын автомашинаар тээвэрлэн ирж өөрсдийн “Төмөртэй”-н талбай дахь тэсрэх бодисын агуулахаас үйлчилгээ үзүүлнэ.

Өрөмдлөг тэсэлгээний параметрийн тооцоо:

1. Цооногийн нийт урт:

$$\text{Хүдэрт: } L_{\text{цо}} = \frac{H_{\text{д}}}{\sin \beta} + L_{\text{иө}} = \frac{10}{\sin 90} + 1 = 11 \text{ м}$$

$$\text{Хөрсөнд: } L_{\text{цо}} = \frac{H_{\text{д}}}{\sin \beta} + L_{\text{иө}} = \frac{10}{\sin 90} + 1 = 11 \text{ м}$$

$H_{\text{д}}$ -Доголын өндөр, м

$L_{\text{иө}}$ -Илүү өрөмдлөг, м

$\sin \beta$ -Цооногийн налуугийн өнцөг, град

2. Илүү өрөмдлөгийн урт:

$$\text{Хүдэрт: } L_{\text{иө}} = (10 - 15) * d_{\text{цо}} = 10 * 0.14 = 1.4 \approx 1 \text{ м}$$

$$\text{Хөрсөнд: } L_{\text{иө}} = (10 - 15) * d_{\text{цо}} = 10 * 0.14 = 1.4 \approx 1 \text{ м}$$

$d_{\text{цо}}$ -Цооногийн диаметр, м

3. Түгжээсний урт:

$$\text{Хүдэрт: } L_{\text{т}} = (20 - 35) * d_{\text{цо}} = 20 * 0.14 = 2.8 \text{ м}$$

$$\text{Хөрсөнд: } L_{\text{т}} = (20 - 35) * d_{\text{цо}} = 20 * 0.14 = 2.8 \text{ м}$$

4. Цооногийн цэнэгийн урт

$$L_{\text{цэ}} = L_{\text{цо}} - L_{\text{т}} = 11 - 2.8 = 8.2 \text{ м}$$

5. 1м цооногийн багтаамж

$$P_{\text{цо}} = 0.785 * d^2 * \Delta = 0.785 * 0.14^2 * 900 = 13.84 \text{ кг/м}$$

$$\Delta\text{-цэнэглэлтийн нягт} / \Delta = 0.9 \text{ тн/м}^3$$

6. Нэг цооногт орох ТБ-ын хэмжээ (багтаамж):

$$Q_{\text{ТБ}} = \frac{\pi * d_{\text{цо}}^2}{4} * L_{\text{цэ}} * \Delta = \frac{3.14 * 0.14^2}{4} * 8.2_{\text{цэ}} * 900 = 113.5 \text{ кг}$$

7. Тэслэх нөхцөлөөр

$$\text{Хүдэрт: } W = \sqrt{\frac{\pi * d_{\text{цо}}^2 * L_{\text{цэ}} * \Delta}{4 * H_{\text{д}} * m * q_{\text{т}}}} = \sqrt{\frac{3.14 * 0.14^2_{\text{цо}} * 8.2 * 900}{4 * 10 * 0.85 * 0.486}} = 50$$

$$\text{Хөрсөнд: } W = \sqrt{\frac{\pi * d_{\text{цо}}^2 * L_{\text{цэ}} * \Delta}{4 * H_{\text{д}} * m * q_{\text{т}}}} = \sqrt{\frac{3.14 * 0.14^2_{\text{цо}} * 8.2 * 900}{4 * 10 * 0.85 * 0.486}} = 50$$

m- цооног ойртолтын коэффициент /m=0,85/

q_т- тэсрэх бодисын тооцооны хувийн зарцуулалт /Хүдэрт: q_т =0,558кг/м³/

/Хөрсөнд: q_т =0,486кг/м³/

8. Өрөмдөгдөх нөхцөлөөр улны эсэргүүцлийн шугам

$$W_0 = C + H_{\text{д}} * Ctg\alpha = 2.5 + 10 * Ctg75^{\circ} = 5\text{м}$$

C-Доголын ирмэгээс 1-р эгнээний цооног хүртэл зөвшөөрөгдөх аюулгүйн зай, м

9. $W \geq W_0$ нөхцөлийн биелэлт хангагдаж байгаа тул улны эсэргүүцлийн 5м байхаар сонгов.

10. Цооног хоорондын зай:

$$\text{Хүдэрт: } a = W * m = 5 * 1 = 5\text{м}$$

$$\text{Хөрсөнд: } a = W * m = 5.2 * 1.1 = 5.7 \approx 6\text{м}$$

m-цооног ойртолтын коэффициент

11. Эгнээ хоорондын зай

Хүдэрт: $b=a*0.85=5*0.85=4.25\approx 4\text{м}$ Хөрсөнд: $b=a*0.85=6*0.85=5.1\approx 5\text{м}$

m-цооног ойртолтын коэффициент

12. 1м цооногоос гарах уулын цул:

Хүдэрт: $g=\frac{((n_{\text{эг}}-1)*b+W)*H_{\text{д}}*a}{((5-1)*4+5)*10*5}=19.09\text{м}^3/\text{м}$

Өрөмдлөг тэсэлгээний ажлын паспортын урьдчилсан үзүүлэлтүүдийг Хүснэгт №4-д, хийгдэх өрөмдлөгийн ажлын тооцоог Хүснэгт №5-д үзүүлэв.

Өрөмдлөг тэсэлгээний ажлын паспортын урьдчилсан тооцоо:

Хүснэгт №4

№	Үзүүлэлтүүд		Хэмжих нэгж	Босоо цооногуудын үед /эгнээ/
1	Цооногийн диаметр		мм	140
2	Цооног хоорондын зай, а	Хөрс	м	6
		Хүдэр		5
3	Цэнэгийн урт	Хөрс	м	8,2
		Хүдэр		
4	Илүү өрөмдлөг	Хөрс	м	1
		Хүдэр		
5	Цооногийн нийт урт	Хөрс	м	11
		Хүдэр		
6	Эгнээ хоорондын зай, в	Хөрс	м	6
		Хүдэр		5
7	Цооног дахь нийт цэнэгийн хэмжээ	Хөрс	кг	113,5
		Хүдэр		
8	ТБ-ын нягт 0,9г/м ³ байхад 1м цооногт орох ТБ-ын хэмжээ		кг/м	13,84
9	Эгнээ ба цооног хоорондын удаашралт	Хөрс	м/сек	20-25
		Хүдэр		
10	1м ³ уулын цул тэслэхэд зарцуулагдах ТБ	Хөрс	кг/м ³	0,486
		Хүдэр	г	0,558
11	1м цооногоос гарах уулын цул	Хөрс	м ³	27,47
		Хүдэр		19,09
12	Нэг цооногоос гарах уулын цул	Хөрс	м ³	301,7
		Хүдэр		209,9

2023 онд уурхайд хийгдэх өрөмдлөгийн ажил

Хүснэгт №5

№	Үзүүлэлт	Хэмжих нэгж	Тоо хэмжээ
1	ӨТА-д хамрагдах талбай	м2	57660
2	2023 онд ажиллах хугацаа	хоног	64
3	Сард ажиллах хугацаа	хоног	30
4	ӨТА-р сийрэгжүүлэх уулын цул:	мян.м3	463,6
	Хөрс	мян.м3	342,5
	Хүдэр	мян.м3	121,1
		мян.тн	508,5
5	Өрөмдөх цооногийн тоо:	ш	4938
	Хөрс	ш	3425
	Хүдэр	ш	1513
6	Өрөмдөх цооногийн нийт урт:	мян.т/м	24,6
	Хөрс	т/м	17125
	Хүдэр	т/м	7568
7	Сард өрөмдөх цооногийн тоо:	ш	2468
	Хөрс	ш	1712
	Хүдэр	ш	756
8	Сард өрөмдөх нийт урт:	мян.т/м	12,3
	Хөрс	т/м	8562,5
	Хүдэр	т/м	3784
9	Хоногт өрөмдөх цооногийн тоо:	ш	82
	Хөрс	ш	57
	Хүдэр	ш	25
10	Хоногт өрөмдөх нийт урт:	мян.т/м	0,2
	Хөрс	т/м	285
	Хүдэр	т/м	126
11	Цагийн бүтээл:	т/м	16
	А. Хоногт ажиллах хугацаа	цаг	24
	Б. Ажлын цаг ашиглалтын коэффициент	К	0,92
	В. Хоногт өрөмдөх цооногийн урт	т/м	353

Тэсэлгээний ажлын тэсэлгээнд зориулагдах тэсрэх бодис болон тэсрэх хэрэгслийг тооцож Маягт № 9-д үзүүлэв.

II.8 Хөрсний овоолго:

Хуулах хөрсийг өмнө нь байгуулсан (ордын зүүн биетээс баруун урд зүгт 2000-2500м, баруун биетээс баруун урд зүгт 750 м зайд) гадаад овоолго руу тээвэрлэнэ.

Тус онд баруун биетээс 342,5 мян.м³ хөрс хуулна. Хөрсний сийрэгжилтийн коэффициент дунджаар 1,5 байна.

Өмнөх онуудад 22.6 га талбай хөрсний гадаад овоолгод өртсөн бөгөөд тус онд гадаад овоолго /өмнөх оны овоолгод/ хийгдэнэ. Гадаад овоолгыг дунджаар тус бүр 15 мөндөр 2 доголоор байгуулна.


Хөрсний гадаад овоолгод D9R бульдозерыг ажиллуулна.

III. БАЯЖУУЛАХ ХЭСЭГ

Баяжуулах хэсэг нь 7-р сарын 1-ээс хуурай орчинд соронзонгоор ангилах 1, 2-р шугам болон нойтон аргаар баяжуулах үйлдвэрийн тоног төхөөрөмжийн засварын ажлыг эхлүүлж хүдэр баяжуулалтын ажил 7-р сарын 1-ээс 11-р сарын 10-ны хооронд / нийт 118хоног / ажиллаж нийт 568,48 мян.тн төмрийн хүдрийг хуурай соронзон сеперацийн аргаар боловсруулж, 52.46%-ийн дундаж агуулгатай 472.4 мян.тн төмрийн бүхэллэг баяжмал үйлдвэрлэн гаргана. Үйлдвэрлэн гаргасан 52.46%- ийн дундаж агуулгатай 472.4 мян.тн төмрийн бүхэллэг баяжмалаас 30.0 мян.тн-ыг нойтон орчинд соронзонгоор ангилан 63.1%-ийн дундаж агуулгатай 12.6мян.тн төмрийн нунтаг баяжмал үйлдвэрлэн гаргана. Тус онд 442.4мян.тн бүхэллэг болон 21.6мян.тн нунтаг баяжмал борлуулахаар төлөвлөж байна.

ТЭЗҮ-д тусгасанаар үйлдвэрүүд хоногт 2 ээлжээр /1 ээлжийн үргэлжлэх хугацаа 12 цаг/ 24 цаг ажиллахаар тусгагдсан бөгөөд ажиллах явцад ажилчдыг росторын хуваарьт шилжүүлэн ажиллуулна.

Үйлдвэрүүд 1, 2-р зурагт үзүүлсэн технологийн схемийн дагуу ажиллахаар төлөвлөв. Төмрийн хүдрийг хуурай соронзон сеперацийн аргаар баяжуулах технологийн схемийг 1-р зурагт үзүүлэв.



1-р зураг: 2022 онд үйлдвэрлэл явуулах технологийн схем

Нэг. Баяжуулах үйлдвэрийн хүчин чадлын тооцоо.

1-р үйлдвэр: Хоногийн хүчин чадал (хүдрээр):

$$Q = Q_{\text{үйлд}} * n * t = 120 \frac{\text{тн}}{\text{ц}} * 2 * 10 = 2400 \frac{\text{тн}}{\text{хоног}}$$

Энд: $Q_{\text{үйлд}}$ – үйлдвэрийн хүчин чадал

n - Баяжуулах хэсгийн ээлжийн тоо

t - Нэг ээлжийн үргэлжлэх хугацаа

2-р үйлдвэр: Хоногийн хүчин чадал (хүдрээр):

$$Q = Q_{\text{үйлд}} * k * t = 130 \frac{\text{тн}}{\text{ц}} * 2 * 10 = 2600 \frac{\text{тн}}{\text{хоног}}$$

Энд: $Q_{\text{үйлд}}$ – үйлдвэрийн хүчин чадал

n - Баяжуулах хэсгийн ээлжийн тоо

t - Нэг ээлжийн үргэлжлэх хугацаа

Үйлдвэрийн сарын хүчин чадал (хүдрээр):

$$Q_{\text{сар}} = Q_{\text{хон}} * N_{\text{сар}} = 2400 \text{тн} * 27_{\text{хон}} = 64800 \text{тн/сар}$$

$$Q_{\text{сар}} = Q_{\text{хон}} * N_{\text{сар}} = 2600 \text{тн} * 27_{\text{хон}} = 70200 \text{тн/сар}$$

$N_{\text{сар}}$ – сард ажиллах хоног/цах. ы саатал, цаг агаарын хүндэрлийг тооцсон
хоног/ жилийн хүчин чадал

Үйлдвэрийн жилийн хүчин чадал (хүдрээр):

$$Q_{\text{жил}} = Q_{\text{хон}} * N_{\text{жил}} = 2400 \text{тн} * 118 = 283200 \text{тн/жил}$$

$$Q_{\text{жил}} = Q_{\text{хон}} * N_{\text{жил}} = 2600 \text{тн} * 118 = 306800 \text{тн/жил}$$

$N_{\text{жил}}$ - жилд ажиллах хоног /цах. ы саатал, цаг агаарын хүндэрлийг
тооцсон хоног /

Хоёр. Баяжуулах үйлдвэрийн техникүүдийн хүчин чадлын тооцоо.

CATD9R маркийн бульдозерын ажлын бүтээл жилд:

$$Q_{\text{буль}} = Q_{\text{ц}} * T * t * k_{\text{ц.а}}, \text{м}^3/\text{жил}$$

$Q_{\text{ц}}$ - цагийн бүтээл (40 м-т түрэх)

T - жилд ажиллах хоног

t - хоногт ажиллах хугацаа

$k_{\text{ц.а}}$ - ажлын цаг ашиглалтын коэффициент

$$Q_{\text{буль}} = 281 * 118 * 22 * 0.85 = 620.1 \text{ мян. м}^3/\text{жил}$$

CLG-856 маркийн дугуйт ачигчийн ээлжийн бүтээл:

$$Q_{\text{ээлж}} = \frac{3600 * E * k_{\text{ш}} * T * k_{\text{а}} * k_{\text{у}}}{t * k_{\text{с}}}$$

Энд: 3600 - цагийг секундээр илэрхийлсэн;

E -шанаганы багтаамж - 3 м³;

$k_{\text{ш}}$ -шанага дүүргэлтийн коэффициент - 0.86;

T -хоногийн ажиллах хугацаа – 22 цаг;

$k_{\text{а}}$ -ээлжийн цаг ашиглалтын коэффициент - 0,85;

$k_{\text{у}}$ -ур чадварын коэффициент -0.8;

t -циклийн үргэлжлэх хугацаа -120 сек;

$k_{\text{с}}$ -сийрэгжилтийн коэффициент - 1.4;

$$Q_{\text{ээлж}} = \frac{3600 * 3 * 0.86 * 22 * 0.85 * 0.8}{t * k_{\text{с}} 120 * 1.4} = 827.1 \text{ м}^3$$

тонн-д шилжүүлвэл:

$$Q_{\text{з}} = 827.1 \text{ м}^3 * 2.45 \text{ тн/м}^3 = 2026 \text{ тн}$$

Ажиллах дугуйт ачигчийн тоо:

$$N_{\text{ач}} = \frac{Q_{\text{үйлд}}}{Q_{\text{ач}}} = \frac{2600}{2026} = 1.3 / \text{нийт 4ш дугуйт ачигч хэрэглэгдэнэ/}$$

Төмрийн хуурай баяжмалын бодисын найрлага

Төмөртэйн голын ордын баруун ба зүүн /хүхэрлэг/ хүдрийн биетийн хүдрийг хуурай баяжуулалтаар гарган авсан хуурай соронзон баяжмалын химийн найрлагыг хүснэгт №6-д үзүүлэв.

Хүснэгт №6

	Fe	P	S	Ba	Al ₂ O ₃	As ₂ O ₃	BaO	CaO	Cr ₂ O ₃	CuO	Fe ₂ O ₃
Баруун биет	52.46	<0.01	0.04	0.01	3.72	0.03	0.02	2.26	0.01	<0.01	75
Зүүн биет	59.96	0.04	2.39	<0.01	2.16	0.02	0.01	4.05	<0.01	0.05	81.44
	K ₂ O	MgO	Mn ₃ O ₄	Na ₂ O	P ₂ O ₅	PbO	SiO ₂	SiO ₃	TiO ₂	V ₂ O ₅	ZnO
Баруун биет	0.55	4.46	0.15	<0.01	0.01	<0.01	12.8	0.09	0.61	0.04	0.03
Зүүн биет	0.28	1.71	0.09	<0.01	0.1	<0.01	7.32	5.97	0.25	0.03	<0.01

Хүдрийн минералогийн фазын шинжилгээ

Төмөртэйн голын ордын гол эрдсүүд нь магнетит, пирит, пирротин, мартит, төмрийн усан исэл, их биш хэмжээгээр ильменит, халькопирит байна. Хүдрийн бус эрдсээс тремолит, моноклин пироксен, серпентин, серецит-мусковитлог гялтгануур, хлорит, кальцит, эпидот, биотит зэрэг орно.

Хүдрийн эрдсийн бичил хатуулаг нь эрдсийн физикийн шинж чанарын салшгүй нэг хэсэг байдаг. Моссын шатлалаар дунджаар магнетит-6.31, пирротин- 4.28, халькопирит-3.92, магнетит-мартит-5.95, төмрийн усан исэл-5.83, пирит-6.72 хатуулагтай гэж тодорхойлсон байна. Хүдрийн эрдсийн найрлагыг хүснэгт №7-д үзүүлэв.

Төмрийн хүдрийн эрдсийн найрлага

Хүснэгт №7

Эрдсийн нэр	Эрдсүүдийн агуулга, %	
	Хүдрийн баруун биет	Хүдрийн зүүн биет
I	II	III
Магнетит	74.6	68.02
Мартит	0.32	0.17
Төмрийн исэл	0.3	0.49
Пирит	0.11	11.24
Пирротин	0.38	2.07
Халькопирит	0.02	0.26
Ильменит	0.04	0.03
Моноклин пироксен	1.73	0.52
Тремолит	1.92	1.98
Серпентин	6.2	6.74
Серицит- мусковит	0.64	0.39
Хлорит	1.86	2.83
Кальцит	6.1	2.75
Эподит	0.01	0.01
Биотит	0.09	0.01

Хуурай орчинд соронзонгоор ялгах үйлдвэрийн тоног төхөөрөмжийн жагсаалт

1-р үйлдвэр

Хүснэгт №8

д/д	Тоног төхөөрөмжийн нэр		Техникийн үзүүлэлт		Тоо ширхэг
	Төрөл	Марк	Хүчин чадал	Хэмжих нэгж	
1	Тэжээх төхөөрөмж	ZSW-590x110	600-840	т/ц	1
2	Хацарт бутлуур	PEF-0710	80-160	м ³ /ц	1
3	Ангилан ялгагч	2YA-1237	70-240	т/ц	1
4	Туузан дамжуурга №6	B650	50	т/ц	1
5	Туузан дамжуурга №7	B650	16	т/ц	1
6	Туузан дамжуурга №8	B650	34	т/ц	1
7	Соронзон сеператор	CTL-0818	45	т/ц	1


8	Туузан дамжуурга №9	B650	24	т/ц	1
9	Туузан дамжуурга №10	B650	24	т/ц	1
10	Туузан дамжуурга №3-2	B1000	200	т/ц	1
11	Туузан дамжуурга №3-3	B1000	200	т/ц	1
12	Конусан бутлуур	PYTB-1750	280-480	т/ц	1
13	Конусан бутлуур	PYTD-1750	75-230	т/ц	2
14	Туузан дамжуурга №1	WMPB1000x27	180	т/ц	1
15	Туузан дамжуурга №2	WMPB1000x42	565	т/ц	1
16	Туузан дамжуурга №3-1	WMPB1000x42	385	т/ц	1
17	Туузан дамжуурга №4-1	WMPB800x17	164	т/ц	1
18	Ангилан ялгагч	YA-1848	150-490	т/ц	2
19	Соронзон сеператор	SCTG-915	70-110	т/ц	2
20	Туузан дамжуурга №5-1	WMPB800x17	16	т/ц	1
21	Туузан дамжуурга №5-2	WMPB800x27	16	т/ц	1
22	Туузан дамжуурга №4-2	WMPB800x45	164	т/ц	1
23	Соронзон сеператор	RCY-G80-1	40	т/ц	1

2-р үйлдвэр


Хүснэгт №9

д/д	Тоног төхөөрөмжийн нэр		Техникийн үзүүлэлт		Тоо ширхэг
	Төрөл	Марк	Үзүүлэлт	Хэмжих нэгж	
1	Тэжээх төхөөрөмж	ZSW-600x130	600-840	т/ц	1
2	Хацарт бутлуур	PE-900*1200	140-260	т/ц	1
3	Конусан бутлуур	КСД2200	710-1100	т/ц	1
4	Ангилан ялгагч	2YA-2160	81-720	т/ц	3
5	Соронзон сеператор	CTL-0918	90-110	т/ц	1
6	Соронзон сеператор	CTDG-0810	250	т/ц	1
7	Туузан дамжуурга №K1	B1000	435-853	т/ц	1
8	Туузан дамжуурга №K2	B1000	435-853	т/ц	1
9	Туузан дамжуурга №K3	B1000	435-853	т/ц	1
10	Туузан дамжуурга №K4	B1000	435-853	т/ц	1
11	Туузан дамжуурга №K5	B1000	435-853	т/ц	1
12	Туузан дамжуурга №K6	B1000	435-853	т/ц	1
13	Туузан дамжуурга №K7	B800	278-546	т/ц	1
14	Туузан дамжуурга №K8	B1000	435-853	т/ц	1
15	Туузан дамжуурга №K9	B800	278-546	т/ц	1
16	Туузан дамжуурга №K10	B800	278-546	т/ц	1
17	Туузан дамжуурга №K11	B800	278-546	т/ц	1
18	Туузан дамжуурга №K12	B800	278-546	т/ц	1

Зураг5: Хаягдлын сангийн план



Зураг6: Хаягдлын сангийн зүсэлт



Мөн үйлдвэрлэлийн үйл ажиллагааг жигд тасралтгүй явуулахын тулд тоног төхөөрөмжүүдийн урсгал засвар болон бусад хийгдэх ажлуудыг урьдчилан тооцож тоног төхөөрөмжийн үзлэг болон засвар үйлчилгээний графикийг гарган мөрдөж ажиллана.

Баяжуулах үйлдвэрийн дэргэдэх шинжилгээний лабораторит үйлдвэрлэлийн анхдагч хүдэр болон баяжмал, хаягдлын ширхэглэлийн ангилал, төмрийн агуулга, бүтээгдэхүүнүүдийн эзэлхүүн жинг тодорхойлох зэрэг ажлуудыг тогтмол хийж, төлөвлөгөөний биелэлтэд хяналт тавьж ажиллана.

Баяжуулах үйлдвэрийн алдагдал хаягдлыг тогтоох хөндлөнгийн технологийн хяналт сорьцлолтыг мэргэжлийн байгууллагаар хийж гүйцэтгүүлнэ.

Тус онд Ил уурхайн болон Ашигт малталыг баяжуулах, боловсруулах үйлдвэрийн аюулгүй ажиллагааны дүрмийг мөрдлөг болгон ажиллана.

Аюулгүй ажиллагааны хүрээнд:

Үйлдвэрийн ажилчдыг аюулгүй ажиллагааны сургалтанд бүрэн хамруулна.

Холбогдох дүрэм журмын хэрэгжилтэнд хяналт тавих.

Баяжуулах үйлдвэрийн тэмдэг тэмдэглэгээг шинэчлэн сайжируулах.

Эргэлдэгч эд ангиудын хаалт хамгаалалтыг сайжируулах зэрэг ажлуудыг хийхээртөлөвлөж байна.

IV. ТЭЭВРИЙН ХЭСЭГ

Тээврийн хэсэгт төмрийн хүдрийн баяжмал тээвэрлэлтэнд 60 тн даацтай автосамосвал-5ш, төмрийн хүдрийн баяжмал ачихад ачигч-1ш, зам засварт зориулан ачигч-1ш, автосамосвал-2ш, автогрейдер-1ш, замын индүү-1ш, усалгааны машин-1ш гэсэн машин техникүүд ажиллана.

Баяжмал тээвэрлэлт нь Авто тээвэр , Төмөр замын тээвэр гэсэн 2 тээвэрлэлттэй.

Төмрийн хүдрийн баяжмалыг “Төмөртэйн гол” УБҮ-ээс Хандгайт болон Талын булаг өртөө хүртэл тээвэрлэнэ. Тээвэрлэлтийг тээвэрлэх эрх бүхий тээврийн зөвшөөрөлтэй тээврийн компанитай гэрээ байгуулан гүйцэтгүүлнэ.

IV.1 Авто тээвэр хийх автосамосвалын тооцоо:

Төмрийн хүдрийн баяжмал тээвэрлэлтийн ажлыг 6 - 12-р сарын хооронд нийт 172 хоногт гүйцэтгэнэ.

Нийт 442.4 мян.тн төмрийн бүхэллэг болон 21.6 мян.тн нунтаг баяжмалыг үйлдвэрийн баяжмалын овоолгоос ачиж, Төмөртэйн өртөө хүртэл тээвэрлэхээр тооцоог хийв.

1. Автосамосвалын даац – 60 тн;

2. Хүдрийн баяжмал ачуулах хугацаа (t_1) – 8-10 мин;
3. Хувийн хэрэгцээнд зарцуулах хугацаа(t_2) – 5 мин
4. Ачаатай буюу ачаагүй явах замын урт – 10 км
5. Төмөр замын ачилтын талбай дээр хүдэр буулгах хугацаа(t_3) /пүүлэх,баримт материал бүрдүүлэх болон бусад хугацаа/ - 20 мин;
6. Ачаатай явах хугацаа(t_4) – 20 мин;
7. Ачаагүй явах хугацаа(t_5) – 15 мин
8. Ачаатай явах дундаж хурд – 30 км/ц;
9. Ачаагүй явах дундаж хурд – 35 км/ц;
10. Ээлжийн үргэлжлэх хугацаа – 1080 мин;
11. Нийт тээвэрлэх төмрийн хүдрийн баяжмал – 359,63 мян.тн

Хоногт тээвэрлэх төмрийн хүдрийн баяжмал:

$$Q_{\text{баяж}} = \frac{V_{\text{с}}}{T} = \frac{218750}{162} = 1350.3 \text{ тн/хон}$$

t - 1 рейс зарцуулах хугацаа:

$$t_{\text{рейс}} = t_1 + t_2 + t_3 + t_4 + t_5$$

$$t_{\text{рейс}} = 10 + 5 + 20 + 20 + 15 = 70 \text{ мин}$$

n - 1 хоногт хийх рейсийн тооцоо:

$$n = \frac{18 \text{ цаг} = 1080 \text{ мин}}{70 \text{ мин}} = 15 \text{ рейс}$$

Хоногт ажиллах шаардлагатай автосамосвалын тоо:

$$N = \frac{Q_{\text{баяж}}}{Q \times n}$$

N – автосамосвалын тоо;

$Q_{\text{баяж}}$ – тээвэрлэх төмрийн хүдрийн баяжмал;

Q – автосамосвалын даац;

n – хоногт хийх рейсийн тоо;

$$N = \frac{1350 * 3}{60 * 15} = 4.5 \approx 5 \text{ ш автосамосвал}$$

IV.2 Дугуйт ачигчийн тооцоо:

Төмрийн хүдрийн баяжмал ачихад 3м³-ийн шанаганы багтаамжтай CLG-856 маркийндугуйт ачигчийг ашиглахаар тооцов.

Дугуйт ачигчийн ээлжийн бүтээл:

$$Q_{y\dot{z}} = \frac{3600 * E_y * k_{ya} * T * k_{yt} * k_{ty}}{k_{ym}}$$

Энд: 3600 -цагийг секундээр илэрхийлсэн;

E - шанаганы багтаамж - 3 м³;

K_{ty} – утгуурт ачигчийн төрлийг тооцох коэффициент – 1.1;

T - Ээлжинд ажиллах хугацаа - 12 цаг;

K_{ya} - цаг ашиглалтын коэффициент - 0,83;

K_{yt} – ачигчийн тээврээр хангагдах нөхцөлийг тооцох коэффициент - 1;

$$Q_{y\dot{z}} = \frac{3600 * E_y * k_{ya} * T * k_{yt} * k_{ty}}{k_{ym}} = \frac{3600 * 1.11 * 12 * 0.83 * 1 * 1.1}{180} = 243.2 \text{ м}^3/\dot{\text{э}}$$

Дугуйт ачигчийн хоногийн бүтээл:

$$Q_{yx} = Q_{y\dot{z}} * k = 243.2 * 2 = 486.4 \text{ м}^3/\text{хоног}$$

Нийт ачих төмрийн хүдрийн баяжмалын хэмжээ:

$$Q_{\text{ж}} = Q_{\dot{z}} * n_{\text{ж}} = 486.4 * 162 = 78.79 \text{ мян.м}^3$$

n_ж -жилд ажиллах хоног

442.4мян.тн төмрийн бүхэллэг баяжмал, 21.6мян.тн төмрийн нунтаг баяжмалыг автосамосвалд ачихад 1ш дугуйт ачигчийн бүтээл хангалттай хүрэлцэж байна.

V. “ТӨМӨРТЭЙН ГОЛ” УБҮ-ИЙН ДЭД БҮТЭЦ

Үйлдвэрийн дэд бүтцийг техник засварын хэсэг болон үйлчилгээ аж ахуйн хэсэг хариуцаж ажиллана. Дэд бүтцэд ажиллагсадын тосгон, засварын газар, цахилгаан хангамж, усан хангамж, харуул хамгаалалт зэрэг объектууд хамрагдана.

V.1 Үйлдвэрийн кемп

Үйлдвэрийн тосгон нь ажиллагсадын байр (вагон сууц болон байшин, гэр), контор, эмнэлэг, цайны газар, хүнс сэлбэгийн болон шатах тослох материалын агуулах, халуун ус, саун, спортын талбай зэргээс бүрдэнэ.

V.2 Засварын газар

УБҮ нь төлөвлөгөөт онд ажиллах шаардлагатай техник, тоног төхөөрөмжүүд, тэдгээрийн засвар, үйлчилгээг тосгоны дэргэд байрлах зориулалтын засварын газарт засварлахаас гадна шаардлага гарсан үед явуулын засварын баг ажиллана.

V.3 Үйлдвэрийн үйлчилгээ аж ахуй

Үйлдвэрийн ээлжийн ажиллагсадыг тээвэрлэхэд 16 хүний суудалтай бага оврын автобус, УАЗ-фургон -1ш, аж ахуйн хэрэгцээнд зориулж ачааны машин -1ш, суудлын машин -5ш, зам услах усалгааны машин -1ш, дизель түлш зөөх, түгээх автоцистерн -1ш гэсэн техникүүдийг ажиллуулна.

V.4 Усан хангамж


5.3. Мэргэжлийн хяналтын улсын байцаагч нь тусгай зөвшөөрөл эзэмшигчийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх явцад илэрсэн зөрчлийн талаарх дүгнэлтээ 15 ажлын өдөрт багтаан Ашигт малтмалын газарт хүргүүлнэ.

5.4. Мэргэжлийн хяналтын ерөнхий газар нь тусгай зөвшөөрөл эзэмшигч энэхүү гэрээгээр хүлээсэн үүргээ хэрхэн биелүүлсэн талаарх санал, дүгнэлтийг жил бүрийн 12 дугаар сард багтаан Ашигт малтмалын газарт хүргүүлнэ.

Зургаа. Орон нутгийн захиргааны байгууллагын эрх, үүрэг

6.1. Орон нутгийн захиргааны байгууллага нь гол, мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох хууль тогтоомж болон энэхүү гэрээний хэрэгжилтийн талаар тухайн орон нутгийн иргэд, иргэний нийгмийн байгууллагуудад мэдээлэл өгнө.

6.2. Тусгай зөвшөөрөл эзэмшигч энэхүү гэрээ болон орон нутагтай хамтран ажиллах гэрээгээр хүлээсэн үүргээ хангалтгүй биелүүлсэн гэж үзвэл орон нутгийн захиргааны байгууллага нь энэ тухай Ашигт малтмалын газарт албан бичгээр мэдэгдэнэ.

6.3. Орон нутгийн захиргааны байгууллага нь энэхүү гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхэд нь тусгай зөвшөөрөл эзэмшигчид зохих журмын дагуу дэмжлэг үзүүлж, хамтран ажиллана.

6.4. Орон нутгийн захиргааны байгууллага нь энэхүү гэрээний хэрэгжилтийн талаарх мэдээллийг гэрээний оролцогч бусад талуудаас зохих журмын дагуу авах эрхтэй.

Долоо. Гэрээний хугацаа

7.1. Гэрээ нь талууд гарын үсэг зурж, баталгаажуулснаар **ХҮЧИН** төгөлдөр болох бөгөөд давхацсан талбайд ашигт малтмал олборлох үйл ажиллагааг дуусгавар болгон уурхайг хааж, нөхөн сэргээсэн талбайг орон нутагт хүлээлгэн өгөх хүртэл хугацаанд хүчинтэй байна. Талууд гэрээний биелэлтийг дараа жилийн 1 дүгээр сард багтаан дүгнэнэ.

7.2. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь давагдашгүй хүчин зүйлсийн улмаас энэхүү гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх боломжгүй тохиолдолд үүссэн нөхцөл байдлын талаар Ашигт малтмалын газарт албан бичгээр мэдэгдэх бөгөөд энэ тохиолдолд шаардлагатай хугацаагаар түүнийг гүйцэтгэх хугацааг сунгана.

7.3. Тусгай зөвшөөрөл эзэмшигч энэхүү гэрээг дүгнэж, дуусгавар болгох хүсэлтийг ирүүлсэн тохиолдолд Ашигт малтмалын газар холбогдох байгууллагуудын оролцоо бүхий Ажлын хэсгийг байгуулан ажиллуулж, гэрээг дүгнэнэ.

Найм. Талуудын хүлээх хариуцлага

8.1. Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн буруутай үйл ажиллагааны улмаас түүний ашигт малтмал ашиглах тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосон тохиолдолд тэрээр энэхүү гэрээгээр хүлээсэн үүргээ бүрэн биелүүлнэ.

8.2. Тусгай зөвшөөрөл эзэмшигч энэхүү гэрээгээр хүлээсэн үүргээ зохих журмын дагуу биелүүлээгүй бол Ашигт малтмалын газар гэрээг дуусгавар болгох бөгөөд энэ тухай гэрээний бусад оролцогчдод албан бичгээр мэдэгдэнэ.

БОАЖЯ, Сэлэнгэ аймгийн Засаг дарга, АМГТГ, МХЕГ, "Эрдэс Групп" ХХК-ийн МV-01 1426 тоот тусгай зөвшөөрлийн талбайд холбогдох арга хэмжээ авах, нөхөн сэргээх үйл ажиллагааны гэрээ

8.3. Тусгай зөвшөөрөл эзэмшигч Монгол Улсын хууль тогтоомж, стандарт, холбогдох бусад эрх зүйн актыг зөрчсөн бол тухайн зөрчлийг илрүүлсэн этгээд энэхүү гэрээг цуцлах нөцтой үр дагавартайгаас бусад тохиолдолд түүнд зөрчлийг арилгуулах хугацаатай үүрэг, даалгавар өгч, биелэлтийг хангуулна.

Ашигт малтмалын газар шаардлагатай гэж үзсэн тохиолдолд зөрчлийг арилгах хүртэлх хугацаанд зохих журмын дагуу ашигт малтмал олборлох үйл ажиллагааг түдгэлзүүлж болно.

Ес. Маргаан хянан шийдвэрлүүлэх тухай

9.1. Талууд энэхүү гэрээтэй холбогдон үүссэн маргаантай асуудлыг харилцан зөвшилцөх замаар шийдвэрлэх бөгөөд тохиролцоонд хүрээгүй тохиолдолд харьяаллын дагуу Монгол Улсын шүүхээр шийдвэрлүүлнэ.

Арав. Бусад зүйл

10.1. Гэрээг монгол хэл дээр ижил хүчинтэй 5 (Таван) эх хувь үйлдэх бөгөөд гэрээний оролцогч тус бүр 1 (нэг) хувийг хадгална.

ГЭРЭЭГ БАЙГУУЛСАН ТАЛУУД:

БОАЖЯ-ны ХБОВНУГ-ын дарга

/П.Цогтсайхан/

АМГТГ-ын УУУТХ-ийн дарга

/Д.Хангай/

Сэлэнгэ аймгийн Засаг дарга

/Ш.Оргил/

МХЕГ-ын ГУУУХ-ийн дарга

/С.Батмөнх-Эрдэнэ/

"Эрдэс Групп" ХХК-ийн захирал

/Д.Чинбат/



ЭРДЭСГРУПП ХХК-Д

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ

**АШИГТ МАЛТМАЛ,
ГАЗРЫН ТОСНЫ ГАЗАР**

Засгийн газрын XI бэйрны баруун жигүүр,
4 дүгээр хороо, Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15170
Утас: 26 38 28, Факс: (976-11) 31 03 70,
Цахим шуудан: info@mgrat.gov.mn,
Цахим хуудас: mgrat.gov.mn

2023 05 24 № 11/2673
танай _____-ны № _____-т

**Гэрээний хугацаа сунгах
тухай**

Сэлэнгэ аймгийн Хүдэр сумын нутагт орших MV-011426 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй Эрдэсгрупп ХХК-тай 2020 оны 02 дугаар сарын 07-ны өдөр Төмөртэйн төмрийн хүдрийн ордын усны сан бүхий газрын энгийн хамгаалалтын бүсэд олборлолт явуулж, нөхөн сэргээх үйл ажиллагааны тухай УС-01/2020 дугаартай гэрээ байгуулсан байна.

АМГТГ-ын даргын 2023 оны 03 дугаар сарын 20-ны өдрийн А/44 дүгээр тушаалаар байгуулагдсан Усны сан бүхий газрын энгийн хамгаалалтын бүсэд олборлолт явуулж эхэлсэн тусгай зөвшөөрөл бүхий талбайд холбогдох арга хэмжээ авах, нөхөн сэргээх үйл ажиллагааны гэрээ байгуулсан ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн гэрээний хэрэгжилтийн тайланг дүгнэх ажлын хэсэг 2022 оны гэрээний хэрэгжилттэй газар дээр нь танилцаж, тайланг хянан хэлэлцээд, ашигт малтмалын ордын тогтоцын онцлогийг харгалзан УС-01/2020 дугаартай гэрээг сунгах нь зүйтэй гэж үзэв.

Хавсралтаар хүргүүлж буй ажлын хэсгийн зөвлөмжийн дагуу хийж гүйцэтгэсэн ажлыг 2023 оны гэрээний хэрэгжилтийн тайланд тусгаж тайлагнах, биелүүлээгүй болон биелэлтийн тайлан ирүүлээгүй тохиолдолд гэрээг цуцлах хүртэл арга хэмжээ авахыг анхаарна уу.

УУЛ УУРХАЙН ХЭЛТСИЙН
ДАРГА

Т.ЗУУННАСТ



5374 04480

Ашигт малтмал, газрын тосны газрын
2023 оны 05 сарын 24 өдрийн
11/2073 дугаар бичгийн хавсралт

ОНЦГОЙ БОЛОН ЭНГИЙН ХАМГААЛАЛТЫН БҮСТЭЙ
ДАВХЦАЛТАЙ ТАЛБАЙГ НӨХӨН СЭРГЭЭХ ТУХАЙ
ЗӨВЛӨМЖ

АМГТГ-ын даргын 2023 оны 03 дугаар сарын 20-ны өдрийн А/44 дүгээр тушаалаар байгуулагдсан Засгийн газрын 2015 оны 03 дугаар сарын 30-ны өдрийн 120 дугаар тогтоолоор батлагдсан "Гол мөрний урсац бүрэлдэх эхийн бүсэд олгосон тусгай зөвшөөрлийг цуцлах, усны сан бүхий газрын энгийн хамгаалалтын бүсэд олборлолт явуулж эхэлсэн, тусгай зөвшөөрөл бүхий талбайд холбогдох арга хэмжээ авах, нөхөн сэргээлт хийлгэх журам"-ын дагуу Усны сан бүхий газрын энгийн хамгаалалтын бүсэд олборлолт явуулж эхэлсэн тусгай зөвшөөрөл бүхий талбайд холбогдох арга хэмжээ авах, нөхөн сэргээх үйл ажиллагааны гэрээ байгуулсан ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн гэрээний хэрэгжилтийн тайланг дүгнэх ажлын хэсэг Сэлэнгэ аймгийн Хүдэр сумын нутаг дэвсгэрт орших Эрдэсгрупп ХХК-ийн эзэмшил MV-011426 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй Төмөртэйн төмрийн хүдрийн ордын талбайтай газар дээр нь танилцаад дараах зөвлөмжийг хүргүүлж байна. Үүнд:

1. Энгийн болон онцгой хамгаалалтын бүсэд нөхөн сэргээлт хийх төлөвлөгөө боловсруулж Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх,
2. Онцгой хамгаалалтын бүстэй давхацсан талбайн хилийн заагийг дахин тогтоож, шав тэмдэгийг сэргээж тайлагнах,
3. Онцгой хамгаалалтын бүсэд байгуулсан технологийн зам, талбайг хааж, нөхөн сэргээлт хийж тайлагнах,
4. Үерийн усны нөлөөгөөр онцгой хамгаалалтын бүсэд бохирдсон хөрсийг нөхөн сэргээхэд анхаарч, БОАЖЯ-ны сайдын А/138 дугаар тушаалаар батлагдсан "Уул уурхайн олборлолтын улмаас эвдрэлд орсон газарт техникийн болон биологийн нөхөн сэргээлт хийх аргачлал"-ын дагуу хөрсний органик болон органик бус бохирдлын хэмжээг тодорхойлох,
5. Онцгой хамгаалалтын бүсэд байгуулсан засварын хэсгийг нүүлгэн шилжүүлэх, хог хаягдал болон шатах тослох материалын үлдэгдлийг цэвэрлэж, саармагжуулах ажлыг нэн даруй гүйцэтгэн тайлагнах

Зөвлөмжийн дагуу хийж гүйцэтгэсэн ажлыг 2023 оны гэрээний хэрэгжилтийн тайланд тусгаж ирүүлэх бөгөөд зөвлөмжид тусгагдсан арга хэмжээг авч хэрэгжүүлээгүй, биелэлтийн тайлан ирүүлээгүй нөхцөлд гэрээг цуцлах хүртэл арга хэмжээ авахыг анхаарна уу.

АЖЛЫН ХЭСЭГ



Батлав:

Эрдэсгрупп ХХК-ийн
захирагч

Л.Мяцагдорж /

Хүлээн авсан:

АМГТГ-ын Уул уурхайн хэлтсийн
дарга Т.Зууннаст /



СЭЛЭНГЭ АЙМГИЙН ХҮДЭР СУМЫН ТӨМӨРТЭЙ ОРДЫН 2023 ОНЫ УУЛЫН АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ



Ашигт малтмалын төрөл: Төмөр
Үндсэн АТЗ-ийн дугаар: MV-011426
Нэмэлт АТЗ-ийн дугаар: 23-0107

Танилцсан: Уул уурхайн хэлтсийн ахлах мэргэжилтэн

П.Зоригт /

БОЛОВСРУУЛСАН:

1. Ерөнхий инженер
2. Уулын инженер
3. Баяжуулагч инженер
4. Механик инженер
5. Эдийн засагч

Р.Гансүх
Н.Болд-Эрдэнэ
У.Ариунболд
У.М.Мамарзоян
Р.Түвшин

2023 он



Аж ахуйн нэгж/ийн нэр: Эрдэс/руул
Тусгай зөвшөөрлийн дугаар: MV-011426
Ашигт малтмалын төрөл: Төмөр
Баяжуулалтын технологи: Нойтон орчинд соронзонгоор

Ашигт малтмал газрын тосны газар

Төлөөлөгөөний он 2023
ТЗЗУ-ээр ашиглах нийт хугацаа: 17
Ашиглалтын хэд дэх жил: 2

Маягт - 1.1



Бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн төлөв

№	Төсвийн зэрэг		Бүтээгдэхүүний хэмжээ		Ашигт малтмалын нэр	Агуулга		Металл (эрдэс)-ийн хэмжээ		Төмбөр
			Хэмжээ нэгж	Тооцон утга		Хэмжээ нэгж	Тооцон утга	Хэмжээ нэгж	Тооцон утга	
1	2	3	4	5	6	7	8	9	10	11
1	ТЗЗУ-ийн хүчин чадвал									
		Боловсруулах хүдэр (элс)-ийн хэмжээ	мян.тн		1		...		...	
	1		мян.тн		1		...		...	
2	2024 онд гаргах бүтээгдэхүүний хэмжээ									
	1	Боловсруулах хүдэр (элс)-ийн хэмжээ	мян.тн	350.00	1	Төмөр (Fe)	%	44.30	мян.тн	155.05
	1	Төмрийн бүхэллэг баяжмал	мян.тн	201.70	1	Төмөр (Fe)	%	52.50	мян.тн	105.90
	2	Төмрийн нунтаг баяжмал	мян.тн	21.60	1	Төмөр (Fe)	%	66.54	мян.тн	14.50
3	2025 онд гаргах бүтээгдэхүүний хэмжээ									
	2	Боловсруулах хүдэр (элс)-ийн хэмжээ	мян.тн	400.00	1	Төмөр (Fe)	%	44.00	мян.тн	176.00
	1	Төмрийн бүхэллэг баяжмал	мян.тн	234.84	1	Төмөр (Fe)	%	52.50	мян.тн	123.30
	2	Төмрийн нунтаг баяжмал	мян.тн	21.60	1	Төмөр (Fe)	%	66.54	мян.тн	14.40
4	2026 онд гаргах бүтээгдэхүүний хэмжээ									
	2	Боловсруулах хүдэр (элс)-ийн хэмжээ	мян.тн	400.00	1	Төмөр (Fe)	%	44.00	мян.тн	176.00
	1	Төмрийн бүхэллэг баяжмал	мян.тн	234.84	1	Төмөр (Fe)	%	52.50	мян.тн	123.30
	2	Төмрийн нунтаг баяжмал	мян.тн	21.60	1	Төмөр (Fe)	%	66.54	мян.тн	14.40

Төлөөлөгөө гаргасан: Ж.Ганзориг
Ерөнхий инженер: Р.Гансүх
Баяжуулагч инженер: Хүлээн авсан: Мэргэжилтэн: Х.Лхагвабаатар



Ая дурын үргэлжлэл нэр:	Эддасгрупп
Тусгай захиаргүйн дугаар:	MTV-011428
Ажилт нийтлэлийн төрөл:	Төлөө

АШИГТ МАЛТМАЛ ГАЗДЫН ТОСНЫ ГАЗАР

Сергей Петрович Мельников	МОРТИН (SPRING)
Телеграммный адрес: 2023	
Телефон и почтовый ящик (с/д) 005	005 50

MART-2.1a



Гармоничны байдлыг үндэслэлийн нээх

[illegible]

Телешумное горлоан	Ж. Ганзориг
Ерөнхий доктор	Р. Гансүр
Бэлгэсүүлэгч эмч нар	Ч. Ариунбол

Х.А. Гусев, доктор
физико-математических наук, профессор
Т.Т. Гусева



Аж ахуйн нэгжийн нэр: Эрдэсруул
Тусгай зөвшөөрлийн дугаар: MV-011426
Ашигт малтмалын төрөл: Төмөр

Ашигт малтмал газрын тосны газар

Баяжуулалтын технологи: Нойтон орчинд
Төлөвлөгөөний он: 2023
Тухайн онд боловсруулах хүдрийн (элс) хэмжээ: 668.50

Маягт-6.2



Уурхайн ус хангамж

№	Хэрэглэгчийн нэвчилт		Эн үүсвэр	Хэмжих нэгж	Тоон утга	Шоометр тутам дахь үнэ тариф (төг/кг)	Төлбөрийн хэмжээ (сая.төг)	Тайлбар
1	2	3	4	5	6	7	8	9
1	Хүн амын унд, ахуйн зориулалтаар ашигласан хэрэглээ	Хүн амын унд, ахуйн зориулалтаар ашигласан хэрэглээ	Гүн (шүүрэл, худаг)	м3/жил	1,300.00	195.00	0.254	
2	Олборлох үйлдвэрлэлийн (ил, далд уурхай) хэрэглээ	Олборлох үйлдвэрлэлийн (ил, далд уурхай) хэрэглээ	-- Сонгох --	м3/жил	0.00	0.00	0.00	
3	Баяжуулах, боловсруулах үйлдвэрийн хэрэглээ	Эргэлтийн усны хэмжээ	Үүсмэл нуур	м3/жил	44,370.00	0.00	0.00	
3		Нэмэлт усны хэмжээ	Ус шавхалт	м3/жил	7,830.00	580.44	4.545	
3		Нийт усны хэмжээ	--	м3/жил	52,200.00	0.00	0.00	
3		Баяжуулах үйлдвэрийн эргэлтийн усны эзлэх хэмжээ	--	%	85.00	0.00	0.00	
4	Байгаль орчин хамгаалах, нөхөн сэргээлтэд хэрэглэх хэрэглээ	Байгаль орчин хамгаалах, нөхөн сэргээлтэд хэрэглэх хэрэглээ	Гүн (шүүрэл, худаг)	м3/жил	3,504.00	580.44	2.086	
5	Усыг шавхан зайлуулах	Усыг шавхан зайлуулах	Гүн (шүүрэл, худаг)	м3/жил	11,424.00	580.44	6.631	
6	Эрэл хайгуулын өрөмдлөг хийх	Эрэл хайгуулын өрөмдлөг хийх	-- Сонгох --	м3/жил	0.00	0.00	0.00	
7	Бусад (Авто зам, Барилга, Хүнд, хөнгөн, хүнсний үйлдвэрлэл, Эрчим хүч, Газар тариалан г.м)	Бусад (Авто зам, Барилга, Хүнд, хөнгөн, хүнсний үйлдвэрлэл, Эрчим хүч, Газар тариалан г.м)	-- Сонгох --	м3/жил	0.00	0.00	0.00	
Нийт хэрэглээ					66,518.00	--	13.515	

Төлөвлөгөө гаргасан: Ж.Ганзориг
Ерөнхий инженер: Р.Гансүх

Хүлээн авсан: Мэргэжилтэн



Аж ахуйн нэгжийн нэр:
Тусгай зөвшөөрлийн дугаар:
Ашигт малтмалын төрөл:

Эрдэс/сүүлт
MV-011426
Төмөр

Ашигт малтмал газрын тосны газар

Баяжуулалтын технологи: Нойтон орчинд
Төлөвлөгөөний он: 2023
Тухайн онд боловсруулах хүдрийн (элс) хэмжээ: 688.50

Маягт-7



Баяжуулах, боловсруулах үйлдвэрийн тоног төхөөрөмжийн жагсаалт

D/c	Тоног төхөөрөмжийн нэр					Техникийн үзүүлэлт			Тоног төхөөрөмжийн насалт			Хэрэглүүрийн чадал			Тайлбар
	Төрөл	Ангилал	Марк	Үйлдвэрлэгч компани	Үйлдвэрлэсэн улс	Хэмжээ, кг/с	Хүчин чадал	Тоо ширхэг	Үйлдвэрлэсэн он	Ашиглалтын дэглэсэн он	Ашиглалтын хугацаа	Хэмжээ, кг/с	Тоон утга	Нийт чадал	
	1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14	
1	Тэжээх төхөөрөмж	Чичиргээт	ZSW600*130	Vepeak	Хятад	тн/цаг	600	1	2011	2011	18	кВт (kW)	22	22.00	
2	Бутлуур	Хацарт	PE900*1200	Vepeak	Хятад	тн/цаг	260	1	2011	2011	18	кВт (kW)	132	132.00	
3	Бутлуур	Конусан	KCD2200T		Орос	тн/цаг	1100	1	2011	2011	18	кВт (kW)	250	250.00	
4	Шигшүүр	Чичиргээт	ZYA2160	Vepeak	Хятад	тн/цаг	720	3	2011	2011	18	кВт (kW)	15	45.00	
5	Соронзон	Хуурай сул соронзон сепаратор	CTL0918	HuiShang group	Хятад	тн/цаг	110	1	2011	2011	18	кВт (kW)	11	11.00	
6	Соронзон	Хуурай сул соронзон сепаратор	CTD30810	HuiShang group	Хятад	тн/цаг	250	1	2011	2011	18	кВт (kW)	18	18.00	
7	Соронзон	Хуурай сул соронзон сепаратор	RCYG80-1	HuiShang group	Хятад	тн/цаг	110	1	2011	2011	18	кВт (kW)	7.5	7.50	
8	Конвейер	Туузан	B1000	Vepeak	Хятад	тн/цаг	853	7	2011	2011	18	кВт (kW)	15	105.00	
9	Конвейер	Туузан	B800	Vepeak	Хятад	тн/цаг	546	7	2011	2011	18	кВт (kW)	7.5	52.50	
10	Тэжээх төхөөрөмж	Чичиргээт	ZSW590*110	Vepeak	Хятад	тн/цаг	340	1	2010	2010	18	кВт (kW)	22	22.00	
11	Бутлуур	Хацарт	PEF0710	NHI	Хятад	тн/цаг	180	1	2009	2009	18	кВт (kW)	90	90.00	
12	Бутлуур	Конусан	PYTB1750	NHI	Хятад	тн/цаг	380	1	2009	2009	18	кВт (kW)	150	150.00	
13	Бутлуур	Конусан	PYTD1750	NHI	Хятад	тн/цаг	230	2	2009	2009	18	кВт (kW)	150	300.00	
14	Шигшүүр	Чичиргээт	ZYA1237	Vepeak	Хятад	тн/цаг	240	1	2010	2010	18	кВт (kW)	7.5	7.50	
15	Шигшүүр	Чичиргээт	YA1848	Vepeak	Хятад	тн/цаг	490	2	2009	2009	18	кВт (kW)	11	22.00	
16	Шигшүүр	Чичиргээт	ZYA2160	Vepeak	Хятад	тн/цаг	720	1	2012	2012	18	кВт (kW)	15	15.00	
17	Соронзон	Хуурай сул соронзон сепаратор	CTL0918	HuiShang group	Хятад	тн/цаг	110	1	2010	2010	18	кВт (kW)	11	11.00	

18	Соронзон	хуурай сул соронзон сепаратор	CTDG0810	HuiShang group	Хятад	тн/цаг	250	1	2010	2010	18	кВт (kW)	15	15.00	
19	Соронзон	Хуурай сул соронзон сепаратор	RCYG80-1	HuiShang group	Хятад	тн/цаг	110	1	2010	2010	18	кВт (kW)	7.5	7.50	
20	Конвейер	Туузан	B1000	NHI, Veepeak	Хятад	тн/цаг	853	5	2009	2009	18	кВт (kW)	15	75.00	
21	Конвейер	Туузан	B800	NHI, Veepeak	Хятад	тн/цаг	546	9	2009	2009	18	кВт (kW)	11	99.00	
22	Конвейер	Туузан	B650	Veepeak	Хятад	тн/цаг	164	6	2010	2010	18	кВт (kW)	7.5	45.00	
23	Тээрэм	Бөөрөнцөгт	MQ2400*6000	NHI	Хятад	тн/цаг	130	1	2017	2017	18	кВт (kW)	250	250.00	
24	Тээрэм	Бөөрөнцөгт	MQ2400*6000	NHI	Хятад	тн/цаг	180	1	2017	2017	18	кВт (kW)	250	250.00	
25	Өтгөрүүлэх, шүүх, хатаах	Гадаад шүүх гадаргуутай хүрдэн вакуум шүүлтүүр	ZPG-40		Хятад	м2	40	2	2017	2017	18	кВт (kW)	18.5	37.00	
26	Соронзон	Нойтон хүчтэй соронзон сепаратор	CTB1534		Хятад	тн/цаг	160	1	2017	2017	18	кВт (kW)	18	18.00	
27	Соронзон	Нойтон хүчтэй соронзон сепаратор	CTB1240		Хятад	тн/цаг	150	2	2017	2017	18	кВт (kW)	18	36.00	
28	Соронзон	Нойтон сул соронзон сепаратор	CTB1234		Хятад	тн/цаг	150	2	2017	2017	18	кВт (kW)	18.5	37.00	
29	Насос	Динамик	100ZJ-I-A36		Хятад	м3/цаг	125	4	2017	2017	18	кВт (kW)	37	148.00	
30	Насос	Динамик	40PV-SP		Хятад	м3/цаг	250	2	2017	2017	18	кВт (kW)	90	180.00	

Төлөөлөгөө гаргасан: Ж.Ганзориг
 Ерөнхий инженер: Р.Гансүх
 Баяжуулагч инженер:

Хүлээн авсан:
 Мэргэжилтэн:



Аж ахуйн нэгжийн нэр:
Ашигт малтмалын төрөл:
Ашиглалтын тусгай зөвшөөрлийн дугаар:

Эрдэсгрупп
Төмөр
MV-011426

Ашигт малтмал газрын тосны газар

Баяжуулалтын технологи: Нойтон орчинд соронзонгоор
Төлөвлөгөөний он: 2023
Тухайн онд олборлох хэмжээ: 668.50

Маягт-10



Байгаль орчны нөхөн сэргээлт

Д/д	Үзүүлэлт	Талбай		Эзэлхүүн		Зардлын хэмжээ		Тайлбар	Сайнбайцал								
		Хамжих нэгж	Тоон утга	Хамжих нэгж	Тоон утга	Хамжих нэгж	Тоон утга		Уртраг			Өргөрөг			Метрийн		
1	Техникийн нөхөн сэргээлт - Гадаад овоолго	га		м3		сая.төг		Хаалтын нөхөн сэргээлттэй орд	№	Град	Мин	Сек	Град	Мин	Сек	Град	Мин
									1								
2	Техникийн нөхөн сэргээлт - Дотоод овоолго	га		м3		сая.төг		Хаалтын нөхөн сэргээлттэй орд	№	Град	Мин	Сек	Град	Мин	Сек	Град	Мин
									1								
3	Биологийн нөхөн сэргээлт - Шимт хөрс	га		м3		сая.төг		Хаалтын нөхөн сэргээлттэй орд	№	Град	Мин	Сек	Град	Мин	Сек	Град	Мин
									1								
4	Биологийн нөхөн сэргээлт - Биологи	га		м3		сая.төг		Хаалтын нөхөн сэргээлттэй орд	№	Град	Мин	Сек	Град	Мин	Сек	Град	Мин
									1								
5	Дүйцүүлэн хамгаалах нөхөн сэргээлт	га	5	м3	2500	сая.төг	4.25	Хаалтын нөхөн сэргээлттэй орд	№	Град	Мин	Сек	Град	Мин	Сек	Град	Мин
									1	107	14	17.4	49	42	34.42	681360.42	2147483.647
									2	107	14	30.66	49	42	27.72	681632.12	2147483.647
									3	107	14	32.02	49	42	33.21	681654.25	2147483.647

									4	107	14	15.29	49	42	28.95	661323.2	2147483.647
6	"Тэрбум мод" үндэсний хөдөлгөөний хүрээнд тарих модны хэмжээ"	га	5	ш	2500	сая.төг	4.5	Хангайн бүсэд	Уртраг			Өргөрөг			Метрийн		
									№	Град	Мин	Сек	Град	Мин	Сек	Град	Мин
									1								
7	Байгаль орчинд нөлөөлөх нөлөөллийг судлах, хамгаалах	га		м3		сая.төг			Уртраг			Өргөрөг			Метрийн		
									№	Град	Мин	Сек	Град	Мин	Сек	Град	Мин
									1								
Нийт		га	10.00	м3	5,000.00	сая.төг	8.75										

Төлөөлөгөө гаргасан: Ж.Ганзориг
Албан тушаал:

Хүлээн авсан:
Мэргэжилтэн:



АШИГТ МАЛТМАЛ,
ГАЗРЫН ТОСНЫ ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2021 оны 02 сарын 14 өдөр

Дугаар Т/43

Улаанбаатар хот

Техник-эдийн засгийн үндэслэл
хүлээн авах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4, Ашигт малтмалын тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.4 дэх хэсэг, Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн 2020 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн Т/20-12-04 тоот дүгнэлтийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Сэлэнгэ аймгийн Хүдэр сумын нутагт орших Эрдэс групп ХХК-ийн MV-011426 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй Төмөртэйн голын төмрийн хүдрийн ордыг ил болон далд уурхайн аргаар ашиглах техник-эдийн засгийн үндэслэл /Тодотгол-I/-ийг хүлээн авсанд тооцсугай.

2. Хүлээн авсан техник-эдийн засгийн үндэслэлийн үйлдвэрлэлийн нөөцийг бүртгэж, геологийн нөөцөөс хөдөлгөөн хийхийг Уул уурхай, судалгааны хэлтэс (С.Энхболд)-т зөвшөөрсүгэй.

3. Ашигт малтмал ашиглах үйл ажиллагааг техник-эдийн засгийн үндэслэлийн дагуу явуулах зөвшөөрөл олгох, хяналт тавьж ажиллах, техник-эдийн засгийн үндэслэл /Тодотгол-I/, түүнийг хуулсан диск, ЭБМЗ-ийн дүгнэлтийн хамт тус байгууллагын архивт хүлээлгэн өгөх ажлыг зохион байгуулахыг Уул уурхай, судалгааны хэлтэс (С.Энхболд)-т даалгасугай.

4. Техник-эдийн засгийн үндэслэлд тусгасан үйлдвэрийн хүчин чадал, техник, тоног төхөөрөмж, технологи, эдийн засгийн тооцоог өөрчлөх тохиолдолд уг техник-эдийн засгийн үндэслэлд тодотгол хийлгэж байхыг Уул уурхай, судалгааны хэлтэс (С.Энхболд)-т даалгасугай.

5. Сэлэнгэ аймгийн Хүдэр сумын нутагт орших MV-011426 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй Төмөртэйн голын төмрийн хүдрийн ордыг ил болон далд уурхайн аргаар ашиглах техник-эдийн засгийн үндэслэл /Тодотгол-I/, түүнийг хуулсан диск, ЭБМЗ-ийн дүгнэлтийн хамт Геологийн баримтын төв архивт, Уул уурхай, судалгааны хэлтэст тус тус хүлээлгэн өгөхийг Эрдэс групп ХХК-д даалгасугай.

ДАРГА

Х.ХЭРЛЭН



53710342



УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН ЯАМ
АШИГТ МАЛТМАЛ, ГАЗРЫН ТОСНЫ ГАЗАР
ЭРДЭС БАЯЛГИЙН МЭРГЭЖЛИЙН ЗӨВЛӨЛИЙН
ДҮГНЭЛТ

2020 оны 12 дугаар сарын 10

№ 7/20-13-04

Улаанбаатар хот

Сэлэнгэ аймгийн Хүдэр сумын нутагт орших MV-011426 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй Төмөртэйн голын төмрийн хүдрийн ордыг ил болон далд уурхайн аргаар ашиглах төслийн техник-эдийн засгийн үндэслэлийн тодотгол I-ийг хэлэлцсэн тухай

"Эрдэс групп" ХХК-ийн захиалгаар Уул уурхайн зураг төслийн "Эрдэнэс инженеринг" ХХК боловсруулсан Сэлэнгэ аймгийн Хүдэр сумын нутагт орших Төмөртэйн голын төмрийн хүдрийн ордыг ил болон далд уурхайн аргаар ашиглах төслийн техник-эдийн засгийн үндэслэлийн тодотгол 1-д Монгол улсын зөвлөх инженер С.Дэлгэрдалай зөвлөж, Монгол улсын зөвлөх инженер Б.Чинзориг шинжээчийн дүгнэлт гаргасан байна. Техник-эдийн засгийн үндэслэлийг Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн ТЭЗҮ хэлэлцэх салбар хуралдаанаар авч хэлэлцэж, дараах ДҮГНЭЛТ-ийг гаргаж байна.

1. Энэхүү техник-эдийн засгийн үндэслэлийн тодотгол 1 нь ЭБЭХ-ийн сайдын 2012 оны 04 дүгээр сарын 17-ны өдрийн 074-р тушаалаар баталсан "Ашигт малтмалын баялгийн урьдчилсан үнэлгээ, ашигт малтмалын ордын нөөцийг ашиглах боломжийн урьдчилсан үнэлгээ, уул уурхайн төслийн техник-эдийн засгийн үндэслэлд тавигдах үндсэн шаардлагууд ба техник-эдийн засгийн үндэслэл хүлээн авах журам"-ын дагуу гүйцэтгэгдсэн байна гэж үзлээ.

2. Техник-эдийн засгийн үндэслэлийн тодотгол 1 нь уншихад ойлгомжтой, цэгц дараалал сайтай, мэргэжлийн түвшинд чанартай сайн боловсруулсан, уурхайг эхлэн байгуулж үйлдвэрлэл явуулах бүхий л шат дамжлага буюу үйл ажиллагааг хамарсан, ашиглалтын үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулах үндсэн баримт бичиг болжээ.

3. Техник-эдийн засгийн үндэслэл нь Төслийн товч тодорхойлолт, геологийн хэсэг, Уул-технологийн хэсэг, Баяжуулалтын технологи, Уурхайн инженерийн хангамж, дэд бүтэц, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй, Уурхайн хаалт ба нөхөн сэргээлтийн ажлын технологи, Эдийн засаг, санхүүгийн үнэлгээ зэрэг 8 бүлэг, Оршил, Дүгнэлт, хавсралт материал бүхий 256 хуудас тайлбар бичиг, 33 хавсралт зургуудаас бүрдэж байна.

4. Төмөртэйн голын ордын MV-011426 тоот тусгай зөвшөөрлийн талбайн нөөцийг Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн 2007 оны 11 дүгээр сарын 23-ны өдрийн хурлын 21/01 тоот дүгнэлтийг үндэслэн гаргасан АМГТХЭГ-ын даргын 2007 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн 472 дугаар тушаалаар (В+С) зэргээр 48.37%-ийн

төмрийн дундаж агуулгатай 16,400.1 мян.тн төмрийн хүдрийн нөөцийг улсын нэгдсэн тоо бүртгэлд бүртгэгджээ.

5. Төсөлд ил уурхайн хил хүрээнд 6,852.64 мян.тн хүдэр багтсанаас ашиглалтын үеийн хаягдал 2.4% буюу 165.9 мян.тн, бохирдол 3.6% буюу 249.2 мян.тн байхаар тооцож үйлдвэрлэлийн магадалсан В' нөөцөд шилжүүлэн тооцсоноор үйлдвэрлэлийн нөөц нийт 6,935.94 мян.тн хүдэр байна. Үйлдвэрлэлийн энэхүү нөөцийг олборлохын тулд 8.06 сая.м³ хөрс хуулалт хийхээр тооцжээ. Энэхүү төсөлд ил уурхайн ашиглалтын эхний 8 жилээр тооцооллыг тусгажээ.

6. Далд уурхайд 8,714.1 мян.тн хүдэр багтсанаас ашиглалтын үеийн хаягдал 5.4% буюу 455.6 мян.тн бохирдол 12.6% буюу 1,053.9 мян.тн байхаар тооцож үйлдвэрлэлийн магадалсан В' нөөцөд шилжүүлэн тооцсоноор үйлдвэрлэлийн нөөц нийт 8,993.4 мян.тн хүдэр байна. Энэхүү төсөлд далд уурхайн ашиглалтын сүүлийн 9 жилээр тооцооллыг тусгажээ Нийт ордын хэмжээнд 15,929.3 мян.тн хүдэр олборлож жилд 1'000.0 мян.тн хүдэр олборлох хүчин чадлаар нийт үйлдвэрлэлийн нөөцийг 17 жилийн хугацаанд ашиглахаар төлөвлөсөн байна.

7. Уурхайн ашиглалтын системийн сонголтыг хийхдээ ордын хүдрийн биетийн тогтоц, шинж чанар, хучаас хөрсний зузаан, хучаас чулуулгийн физик механик шинж чанар зэргийг харгалзан үзэж ил уурхайд авто тээвэртэй, гадаад овоолготой ашиглалтын систем, далд уурхайд давхраар албадан нураах ашиглалтын систем тус тус хэрэглэх нь оновчтой гэж үзжээ.

8. Ил уурхайн өрөмдлөгийн ажилд DC-726B маркийн өрмийн машин 2ш, хөрс хуулалтад болон хүдэр олборлолтод 5.4 м³ утгуурын багтаамжтай CAT-390DL маркийн экскаватор 2 ширхэг, 3.0 м³ утгуурын багтаамжтай Hyundai 500LC-7 маркийн экскаватор 1 ширхэг, хөрс болон хүдэр тээвэрт 57 тн-н даацтай MT-86 маркийн автосамосвал 5 ширхэг, хөрсний овоолгод CAT-D9R маркийн бульдозер 1 ширхэг, хүдэр буулгах талбайд 3.0 м³ утгуурын багтаамжтай LG956L маркийн утгуурт ачигч 1 ширхэг, далд уурхайн шпур өрөмдөх ажилд HT81A маркийн өрмийн машин 2 ширхэг, YT-28 маркийн (перфоратор) гар өрмийг 3 ширхэг, HYKD-3A маркийн өрмийн суурин машин 14 ширхэг, хоосон чулуулаг болон хүдэр ухаж ачих ажилд WJ-2 маркийн ачигч машин 3 ширхэг, зөөвөрлөх, тээвэрлэх ажилд UK-20 LP маркийн автосамосвал 8 ширхэг тус тус үндсэн тоног төхөөрөмжүүдийг ашиглахаар төлөвлөжээ.

9. Хүдэр баяжуулах үйлдвэрийн баяжуулах технологийг захиалагч талаас өгсөн техникийн даалгавар болон "Геологийн төв лаборатори" ХХК-ийн туршилтын үр дүнд үндэслэн урьдчилсан байдлаар сонгосон байна. Баяжуулах үйлдвэрийн хүчин чадал нь хуурай баяжуулах үйлдвэр 1,000.0 мян.тн/жил, нойтон баяжуулах үйлдвэр 800 мян.тн/жил тус тус байна.

10. Жил бүр төмрийн хүдрийг хуурай болон нойтон аргаар баяжуулж жилд дунджаар 492.75 мян.тн баяжмал үйлдвэрлэхээр тооцсон байна.

11. Уурхайн цахилгаан хэрэглэгчдийг Сэлэнгэ аймгийн Ерөө сумын нутагт орших Толгойт дэд станцаас Хүдэр сумыг холбосон 35кВ-ын өндөр хүчдэлийн агаарын шугамын 141 дэх анкерны тулгуураас өөрийн үйлдвэр хүртэл 10.2 км урттай 35 кВ-ын агаарын шугамыг барьж байгуулсан. Мөн 1600 кВА бүрэн чадал бүхий 35/6 кВ-ын ерөнхий бууруулах дэд станцыг барьж байгуулан үйлдвэрийн болон бусад цахилгааны хэрэгцээг хангахаар тооцжээ.

12. Уурхайн усан хангамж тус орд нь Ерөө голын сав газарт хамаарна. Ил уурхайд дунджаар 6934.2 м³/хоног ус шүүрч орж ирэх ба үүнийг ЦНС 300-120 маркийн

шахуургийн тусламжтай шилжүүлнэ. Далд уурхайд 104681.88 л/хоног технологийн ус хэрэглэх тооцоо гарсан ба үүнийг шүүрлийн усаар хангахаар тооцоолжээ.

13. Нойтон соронзон аргаар баяжуулах үйлдвэрийн технологийн хэрэгцээт усны эх үүсвэрийг ордын раойнд хийгдсэн газар доорх усны ерөнхий эрэл, урьдчилсан хайгуулын ажлын үр дүнд тодорхойлогдсон цоонуудад гүний худаг гарган хангах болон уурхайд орж ирэх шүүрлийн усыг хуримтлуулан ашиглахаар тусгажээ. Баяжуулах үйлдвэрийн нийт хэрэгцээт ус 1549.8 мян.м3/жил, үүнээс эргэлтийн ус нь 83.4% буюу дундажаар 1292.5 мян.м3/жил, нэмэлтээр буюу цэвэр ус нь 16.6 % буюу дундажаар 257.27 мян.м3/жил ус ашиглахаар тусгажээ. Уурхайгаас төмөртэйн уурхайн ачих буулгах өртөө хүртэл 0.7 км хатуу хучилт авто замаар тээвэрлэн төмөр замаар Замын-үүд боомтоор БНХАУ-д экспортлоно.

14. Байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээлт ба хаалтын зардалд нийт 2,722.1 сая төгрөг зарцуулахаар тооцсон байна. Үүнээс байгаль орчныг хамгаалах ажилд жилд 30.0 сая.төгрөг, техникийн нөхөн сэргээлтийн зардалд 1,297.33 сая.төгрөг, биологийн нөхөн сэргээлтийн зардалд 677.76 сая.төгрөг, хяналт-шинжилгээний зардалд 237.01 сая.төгрөг тус тус зарцуулахаар төсөлд тусгажээ.

15. Уг төслийг хэрэгжүүлснээр 324-511 хүн ажлын байраар хангагдах ба уурхайн ажилчдын сарын дундаж цалин 1,875.40 мян.төг байхаар байна.

16. Төмөртэйн голын төмрийн хүдрийг ашиглах ил болон далд уурхайн төсөл хэрэгжүүлэхэд нийт 45.28 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт шаардлагатай байна. Үүнээс биет бус хөрөнгө оруулалт 986 сая төгрөг, ил уурхайн үндсэн техник, тоног төхөөрөмжийн хөрөнгө оруулалт 25.9 тэрбум төгрөг, баяжуулах үйлдвэрийн хөрөнгө оруулалт 12.08 тэрбум төгрөг, дэд бүтцийн хөрөнгө оруулалт 3.99 тэрбум төгрөг, магадалшгүй ажлын хөрөнгө оруулалт 401.6 сая төгрөг байхаар тус тус тооцжээ. Элэгдэл хорогдлын шимтгэлийн зардалд жилд дунджаар 40.1 тэрбум төгрөг байхаар тооцоолсон байна.

17. Уурхайг ашиглах төслийн хугацаанд нийт 1,318.48 тэрбум төгрөгийн үйл ажиллагааны зардал гарган, 1,643.5 тэрбум төгрөгийн борлуулалт хийж 330.23 тэрбум төгрөгийн татварын өмнөх ашигтай ажиллахаар байна. Татвар ногдуулсны дараах байдлаар нийт 262.28 тэрбум төгрөгийн цэвэр ашигтай, 226.79 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтын дараах мөнгөн урсгалтай ажиллахаар байна. Улс, орон нутгийн төсөвт 237.93 тэрбум төгрөг төвлөрүүлэхээр тусгажээ. Уурхайн ашиглалтын хугацаанд нэгж бүтээгдэхүүний бүрэн өөрийн өртөг 161.60 мян.төг/тн байна.

18. Төсөл хэрэгжих хугацаанд нийт 226.79 тэрбум төгрөгийн үйл ажиллагааны мөнгөн урсгал бий болох бөгөөд төслийн өнөөгийн цэвэр үнэ цэнэ (NPV, @10%) 78.14 тэрбум төгрөг, өгөөжийн дотоод норм (IRR) 35.5 %, хөрөнгө оруулалтаа нөхөх хугацаа 3.95 жил байхаар тооцжээ.

Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлөөс техник-эдийн засгийн үндэслэлийн захиалагч, боловсруулагч болон төслийн шинжээчид дараах асуудлыг анхааруулж байна.

1. Төсөлд шаардлагатай мэргэжлээр Монгол Улсын иргэдийг бэлтгэх, тэдгээрийг ажлын байраар хангах, нийгмийн асуудлыг шийдвэрлэх, нийгмийн өмнө хүлээсэн үүргээ биелүүлж ажиллахыг төсөл хэрэгжүүлэгчид анхааруулж байна.

2. Байгаль орчныг хамгаалах, эвдэрсэн газрыг нөхөн сэргээх, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудалд онцгой анхаарч холбогдох байгууллагуудтай хамтран ажиллахыг ЭБМЗ-өөс даалгаж байна.
3. Засгийн газрын 379-р тогтоолоор батлагдсан "Тусгай зориулалтын авто зам, замын байгууламж барих, ашиглах журам"-ын хэрэгжилтийг хангаж ажиллахыг тусгай зөвшөөрөл эзэмшигч компанид анхааруулж байна.
4. Техник-эдийн засгийн үндэслэлд тусгагдсан техник, технологийн сонголт, уулын ажлын төлөвлөлт, цахилгаан хангамж, дэд бүтцийн сонголт, байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээлт, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шийдлийн талаар төслийн эдийн засгийн үнэлгээг боловсруулсан Уул уурхайн зураг төслийн "Эрдэнэс инженеринг" ХХК, мөн ТЭЗҮ-ийн үнэн бодит байдал, чанарт дүгнэлт гаргасан шинжээч Монгол Улсын зөвлөх инженер Б.Чинзориг тус тус хариуцна.

Техник-эдийн засгийн үндэслэлд хийсэн шинжээчийн дүгнэлт, зөвлөлийн гишүүдийн саналыг үндэслэн Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн Салбар хуралдаанаас Ашигт малтмалын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.4, 48 дугаар зүйлийн 48.4, Газрын хэвлийн тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.2 дахь хэсгүүд болон энэ дүгнэлт, холбогдох хуулийн заалтуудыг тус тус үндэслэн дараах шийдвэр гаргахыг Ашигт малтмал, газрын тосны газрын даргад уламжлахаар тогтов. Үүнд:

1. "Сэлэнгэ аймгийн Хүдэр сумын нутагт орших MV-011426 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй Төмөртэйн голын төмрийн хүдрийн ордыг ил болон далд уурхайн аргаар ашиглах техник-эдийн засгийн үндэслэлийн тодотгол 1"-ийг хүлээн авах;
2. Техник-эдийн засгийн үндэслэлд тусгасан уурхайн хүчин чадал, техник тоног төхөөрөмж, технологи, эдийн засгийн тооцоог өөрчлөх тохиолдолд уг техник-эдийн засгийн үндэслэлд тодотгол хийлгэж ЭБМЗ-ийн салбар хуралдаанаар хэлэлцүүлж байхыг төсөл хэрэгжүүлэгчид анхааруулах.
3. Сэлэнгэ аймгийн Хүдэр сумын нутагт орших MV-011426 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй Төмөртэйн голын төмрийн хүдрийн ордыг ил болон далд уурхайн аргаар ашиглах техник-эдийн засгийн үндэслэлийн тодотгол 1, түүнийг хуулсан диск, ЭБМЗ-ийн дүгнэлтийн хамт Геологийн баримтын төв архивд холбогдох шаардлагад нийцүүлэн хүлээлгэн өгөх арга хэмжээг авах.

ТАНИЛЦСАН:

ЭРДЭС БАЯЛГИЙН МЭРГЭЖЛИЙН
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА

Б.ЭЛБЭГЗАЯА

ХУРАЛДААНЫГ УДИРДСАН:

ЭРДЭС БАЯЛГИЙН МЭРГЭЖЛИЙН
ЗӨВЛӨЛИЙН САЛБАР
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА

Ч.ЦОГТБААТАР

БОЛОВСРУУЛСАН:

ЭРДЭС БАЯЛГИЙН МЭРГЭЖЛИЙН
ЗӨВЛӨЛИЙН САЛБАР ЗӨВЛӨЛИЙН
НАРИЙН БИЧГИЙН ДАРГА

Э.МӨНХЗОРИГ

**СЭЛЭНГЭ АЙМГИЙН ХҮДЭР СУМЫН НУТАГТ
ОРШИХ ТӨМӨРТЭЙН ГОЛЫН ТӨМРИЙН
ХҮДРИЙН ОРДЫГ ИЛ БОЛОН ДАЛД УУРХАЙН
АРГААР АШИГЛАХ ТЕХНИК ЭДИЙН ЗАСГИЙН
ҮНДЭСЛЭЛ/ТОДОТГОЛ-I/**

(Тусгай зөвшөөрлийн дугаар: МУ- 011426)

(Жилийн хүчин чадвал: 1000.0 млн.тн хүдэр)

ТӨСӨЛ ХЭРЭГЖҮҮЛЭГЧ: “ЭРДЭС ГРУПП” ХХК

Гүйцэтгэх захирал Л.Чинбат

ТӨСӨЛ БОЛОВСРУУЛАГЧ: “ЭРДЭНЭС ИНЖЕНЕРИНГ” ХХК

Төслийн удирдагч,

Уул уурхайн мэргэшсэн инженер Б.Баяраш

Төслийн зөвлөх, МУ-н зөвлөх инженер С.Дэлгэрдалай

Уулын инженер Н.Даваасүрэн

Уулын инженер С.Сэргэлэн

GIS-ийн инженер Б.Алтанзагас

УЛААНБААТАР 2020 ОН

БАТЛАВ:
"ЭРДЭС ГРУП" ХХК-ийн
Гүйцэтгэх захирал:

Л.ЧИНБАТ

ТАНИЛЦСАН:
ЭБМЗ-ийн дарга:

Б.ЭЛБЭГЗАЯА

ХЯНАСАН:

ЭБМЗ-н салбар зөвлөлийн нарийн бичгийн дарга.....МӨНХЗОРИГ

ТӨСӨЛ БОЛОВСРУУЛАГЧ: "ЭРДЭНЭС ИНЖЕНЕРИНГ" ХХК-ийн

Төслийн удирдагч,

Уул уурхайн мэргэшсэн инженер.....Б.Баяраа

Уулын инженер,

Монгол улсын зөвлөх инженер.....С.Дэлгэрдалай

Уулын инженер.....Н.Даваасүрэн

Уулын инженер.....С.Сэргэлэн

Баяжуулагч инженер.....Х.Ариунзаяа

Эдийн засагч.....А.Туяагэрэл

GIS инженер.....Б.Алтанзагас

ТӨСЛИЙН ШИНЖЭЭЧ:

Монгол улсын зөвлөх инженер.....Б.Чинзориг



**СЭЛЭНГЭ АЙМГИЙН
БАЙГАЛЬ ОРЧИН,
АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗАР**

213200 Сүхбаатар сум, Сэлэнгэ аймаг,
Утас/Факс: (976)-7036-3853

2023.08.14 № 608
танай 2023.08.07-ны № 16-т

Санал хүргүүлэх тухай

Танайхаас ирүүлсэн 2023 оны 08 дугаар сарын 07-ны өдрийн 16 тоот албан хүсэлттэй танилцлаа.

Төмрийн хүдрийн үнэ унасан шалтгаанаас үүдэн уулын ажил хийгдэхгүй, зөвхөн өмнөх жилүүдэд олборлосон төмрийн хүдрийг боловсруулах нэг сарын ажил хийгдэхээр төлөвлөж 5 га талбайд биологийн нөхөн сэргээлт, Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачлагаар хэрэгжиж буй "Тэрбум" үндэсний хөдөлгөөний хүрээнд 5 га талбайг нөхөн сэргээх санал ирүүлснийг дэмжиж байна. Дээрх саналуудыг 2023 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тусган батлуулж, холбогдох журам, стандартын дагуу нөхөн сэргээлт хийж, ойжуулж хамтран ажиллана уу.

Жич: Байгаль орчин аялал жуулчлалын Сайдын 2023 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн 02 дугаар албан даалгаврын 4 дэх хэсэгт заасны дагуу хөрсний бохирдлоос урьдчилан сэргийлэх зорилгоор био болон боловсон 00 бий болгох шаардлагатай.

ДАРГА



З.ТҮВШИНТӨГС

